

МАНЖ АЛБАН БИЧГИЙН ХҮНДЭТГЭЛ
ИЛЭРХИЙЛЭХ ЁСНООС*

Э. Мөнх-Учрал*

Манж нарын бичгийн соёлын тухайд энэхүү өгүүлэл холбогдоно. Өрнө, дорно дахинаа манж хэл бичгийг олон талаас хараалан судалсаар ирсний дотор бичгийн соёлын судалгаа дутмаг байсаар ажээ. Аливаа бичиг үсэг сайтар хөгжсөн цагт тухайн үндэстэн өөрийн гэсэн бичгийн соёлтой болдог. Эрхэмлэн хүндэтгэх хандлагаа илгээж буй бичгээрээ илэрхийлэх нь уг соёл төгөлдөржин боловсорсны хэмжүүр агаад төр улс мандан бадарч, бичиг үсгийн хэрэглээ гүрэн даяарт түгэхийн хэрээр бичгийн соёл, тэр дундаа албан бичгийн хүндэтгэлийн хэв маяг олон зүйл болон өргөжин тэлдэг. Аль нэгэн үндэстний бичгийн соёлын бүрэн судалгаа нь Я. Цэвэл гуай монголын тухайд “Монголын албан бичгийн талаар хэвшсэн нарийн ёс дэглэмийн бүх зүйлийг тал бүхнээс нь учир бүртгэж нарийвчлан судлах хэмээвээс маш төвөгтэй их ажил мөн бөгөөд нягт судалгаа, урт хугацаа шаардагдах болох юм”¹ хэмээн дурдсантай агаар нэг тул, уг өгүүллийн хүрээнд манж албан бичигт хүндэтгэл илэрхийлэх ёсыг улсын дээд хүмүүн болох хаан эзнээ хүндэтгэх байдлаар жишээлэн судлахыг зорилоо.

Дэлхийн түүхэнд нэрээ гаргасан “бүдүүлгүүд буюу харийнхан”²-ы нэг болох манж нар шууд Манжуурын ойгоос гарч тулалдан, хүйгээр нь авсаар Хятадад эзэн суугаагүйг Овен Латтиморе анхлан онцолсны³ адилаар, тэд бас гэнэт бичгийн соёлтой болсон хэрэг биш ээ. Иймд манж нарын бичиг үсэг хэрэглэж ирсэн байдлыг товч дурдъя.

* Энэхүү өгүүллийг ХБНГУ-ын “Gerda Henkel Stiftung”-гийн AZ04/ZA/08 төслийн хүрээнд бичив.

* Бонны Их Сургууль

¹ Я. Цэвэл 1959, 3 дугаар тал.

² Анхандаа хэлж байгаа нь мэдэгдэхгүй буюу грек хэл мэддэггүй гэдэг утгаар ХТӨ V зуунд грекчүүд персчүүдийг хэлж байсан гр. *barbaros* хэмээх нэрийг Грек, Ром зэрэг өрнийн соёлын төв болсон улсууд өөрсдөөсөө өөр соёлтныг нэрлэхдээ авсан нь яваандаа “иргэниээгүй буюу бүдүүлэг” нэгнийг заах болсон билээ. Дорно дахинд, Эеэр засагчийн 3-р онд (1646) зарлигаар зохиосон “Алтан улсын судар”-ын I дэвтэрт, Хятан улсад орж өмнөдөд суусныг “үрэхэ нюй жи”, Хятанд ороогүй хойдод суугсдыг “эсхүн нюй жи” хэмээсэн буй. Ма. “urehe” нь болсон, боловсорсон, “eshun” нь түүхий гэсэн утгатай. Тэгэхээр Хятаны өнцгөөс, дагаар орсон нь соёлтой боловсон, дагаагүй нь боловсон бус болно.

³ Овен Латтиморе 1940, 1951.

Хятадын эх газартай Шаньхайгуаний гарцаар холбогдох Манжуурын бүс нутагт түнгүс, монгол, хятад угсаатнууд тус тусын ахуй амьдралын хэв маягаар өөр хоорондын харилцаатай оршиж иржээ. Тиймээс энэ нутагт аль үндэстэн төр улсаа байгуулан товойн гарч ирнэ, түүний бичиг үсгийг нийтээр хэрэглэж байв. Тодруулбал, Хянгану нурууны зүүн бие, Хятадын хойд хэсгээс төр улсаа байгуулсан, монголтой угсаа гарлын холбоотой Хятаны Ляо улс (хя. *liao* 遼 906-1125)-ын үед хятан бичгийг⁴, Манжуурын уулархаг ойн нутгаас эхтэй түнгүс угсааны Жүрчидийн Алтан улс (хя. *jin* 金, 1115-1234)-ын үед жүрчин бичгийг,⁵ гурван голын сав газраас үүдсэн монголын Их Монгол улс (1206-1269), Юань улс (хя. *yuann* 元, 1269-1368)-ын үед монгол бичгийг хэрэглэжээ. Ляо голын сав газар, Ляодунгаас доош Шаньхайгуань хүрэх зурвас, Ляодунгийн хойгийн эрэг орчим, Ялү голын нам дор хөндий нь өнө удаан нангиад соёлын хөрс байж, дурдсан улсуудаас өмнө хийгээд Мин улс (хя. *ming* 明, 1368-1644)-ын үед ханз үсэг хэрэглэсээр ирсэн. Мэдээжээр, улс мөхөхөд бичиг үсэг нь хэрэглээнээс арчигдана хэмээх шиг наагуурдсан хэрэг үгүй. Дээр өгүүлснээс, Манжуурын нутаг эртнээс олон бичгийн соёлтой танилцаж, туршлага хуримтлуулсан байсныг харж болно.

Мин улсаас хил хязгаараа цагдан сэргийлүүлэхээр байгуулсан вэй (хя. *wei* 衛)-гийн нэг болох Урт цагаан уул (ма. *volmin sanggiyan alin*, хя. *chang bai shan* 長白山) орчмын Жяньжоу жүрчин (хя. *jian zhou* 建州) нар⁶ бол Манжийн Алтан улс (хя. *jin* 金, 1616-1644), улмаар Их Чин улс (хя. *dai qing* 大清 1644-1911)-ын уг язгуур билээ. Жяньжоугийн жүрчидийн ноён Нурхачи⁷ (1559-1626) тугдмаар байгуулж буй улсаа өөрийн гэсэн бичиг үсэгтэй болгохын төлөөнөө 1599 онд Эрдэнэ багш, Гагай заргач нарт зарлиг буулгаснаар, монгол бичгийг хувилгаж манж бичиг бий болсныг “*Дайчин улсын Тайзү дээд хуандийн магад хууль*”-аас бид мэддэг. Гагай заргач тэр жилдээ төрд тэрсэлсэн хэргээр цаазлагдсан тул Эрдэнэ багш зарлигийг голлон гүйцэлдүүлжээ.⁸ Манж нар өмнө дурдсанчлан, олон үндэстний олон бичгийг гадарлах төдийгүй “доторлож” байсан атал юуны учир монгол бичгээс улсын бичгээ үүтгэсэн бэ? Нурхачи баруун дахь Фүшүнь, баруун өмнөдийн Чинху, өмнөдийн Айян, Гуандяньд арилжааны зээл нээх хэлэлцээр хийж, ангийн үсийг хятадын хөвөн даавуу, чихэр, амуу будаагаар сольж байсан⁹, Бээжинд алба хүргэхээр биечлэн явж байсныг авч

⁴ Ляо улсын судрын баримтаар, 920 онд хятан их бичиг, 925 онд хятан бага бичиг зохион хэрэглэсэн.

⁵ Алтан улсын судрын баримтаар, 1119 онд жүрчин их бичиг, 1138 онд бага бичиг зохион хэрэглэжээ.

⁶ Эртний хятад түүхэст жүрчинийг Сүшэн (хя. *sushen* 肅慎)-д хамаатай, нум сумны алба өгдөг гэдэг. Х зуунд Хятаны эрхшээлийн үед Нюйжэн (хя. *ni-zhen* 女真) байсныг 眞 үсгийг цээрлэж, Нюй жы (хя. *ni-zhi* 女直) болов. Нюй (хя. 女) үсгийн устай хувилбар (хя. 女) -ыг “жү” гэж уншдгаар “жүжэсн - нюйжэсн”-ийг тайлбарладаг. Юань улсын сударт “*Усны татар*”, зарим овгийг одоо хүртэл “*загасчин татар*” гэх аж. Мингийн үед Жүшэнь (хя. *zhushen* 諸申) нь Жяньжоу (хя. *jian zhou* 建州), Хайси (хя. *hai xi* 海西), Ежэнь (хя. *ye-ren* 野人) гэсэн 3 гол аймагтай байжээ. XVI зуунд Жяньжоу жүрчин Ляодунгийн зүүн, Ялү мөрний хойд хэсгийг эзэмшиж, Хайси Мүгдэний хойд хэсгээр нутаглаж, Ежэнь зүүн хойш амьдарч байв. Жяньжоу жүрчин хойд зүгийн Саньшин, Сүнгари голоос гаралтай ба Хурга гол, Нингүтагаар дамжин Чанбайшань руу нүүж иржээ. Латтимор “*Жяньжоу*” нэрийг “*Жиний овог*” буюу “*Жиньзү*”-гийн гажуудсан хэлбэр байж магадгүй, Горьский Нурхачийг Жинь улсын хунтайжийн арван үеийн шууд хойчис гэжээ. Тэд 1635 оноос л өөрсдийгөө “манж” хэмээн нэрлэсэн. О. Латтиморе 1951, 116, 29 дүгээр зүүлт, Хенри Серруйс (Henry Serruys) 1955, 28-41, Франц Михайл 1965, 39, 1, 2 дугаар зүүлт, “*Дусал бинтгүй үсгийн данс*” (ДБҮД) IX, 4509 дүгээр талд үзнэ үү.

⁷ Нурхачи Жүрчин аймгийн үе дамжсан овгийн тэргүүлэгчдийн Айсин гиоро овогт төрсөн. Нурхачийн гэр бүл Жяньжоугийн жүрчинээс гаралтай бөгөөд өвөг дээдсийн нэг нь магадгүй Юань улсын үед овгийн ахлагч байжээ. Хюммел (Hummel) 1964, 594-599 дүгээр талд үзнэ үү.

⁸ Мөн тэнд, 225-226 дугаар талд үзнэ үү.

⁹ Росс (Rev. John Ross) 1973, 11 дүгээр талд үзнэ үү.

үзвэл¹⁰, Хятад орон, хятад соёлыг тодорхой хэмжээнд танин мэдсэн нь лавтай. Жүрчиний дунд монгол соёл эртнээс дэлгэрсэн хийгээд түүний дээд өвөг Юань улсын үед овгийн ахлагч байсан¹¹ болон манж бичиг зохиохоос өмнө улсын хэргийг монгол хэлээр орчуулан явуулж байсан тул тэр бээр монгол бичгийн боловсролтой нэгэн болно. Ялангуяа Нурхачи 8 эрдэмтнийг “багш”¹² тушаалд “зөвлөх”-өөр авсан ба тэд угаасаа олон соёлт байсан, харин нангиадажсан төлөөлөгч (*‘agent’*) байгаагүй аж.¹³ Тэгтэл, “олон соёл”-ыг шингээсэн 8 багшийн дотроос, Эрдэнэ багшид улсын чухал хэргийг онцгойлон даалгасан нь сонирхол татна. Эн түүнд түүний монгол, хятад хэлэнд нэвтэрсэн, эрдмийн цараатай холбоотой.¹⁴ Үүнийг “*Дусал бинтгүй үсгийн данс*”-нд: “*Дэлхий дахинаа аливаа сайн эдийг олох хялбар, сайн хүнийг олох бэрх хэмээжүхүй. Эрдэнэ багшийн бусад гавьяаг мэдэхгүй, бичгийн гавьяа мэдэх нь, Гэгээн хааны явсан журмыг түүний дураар тулгар бичиж бүтээсэн нь мөн зэрэг гавьяанаас гарсан их гавьяа хэмээн санамуй*” хэмээсэн нь батална.¹⁵ Ийн зарлиг буулгасан, хүлээсэн хүмүүсийн боловсролын дээр, манж хэл, монгол хэлтэй гарлын хувьд ижил, хэв шинжийн талаар адилхан залгамал хэл гэдэг нь хэлшинжлэлийн шалтгаан ба өмнө дурдсанчлан үүнийг бүрэн танихуйцаар монгол бичгийг хэрэглэсэн байв. Манж хэлэнд орсон болон манж, монгол хэлний дундын олон үг үүний бодтой баримт юм.¹⁶ Басхүү нэн чухал нь, нийгэм орчны тухайд хол өвгийн угсаа гарал, газар зүйн байрлал, худ ургийн барилдлага, шашин шүтлэг, соёл, улс төрийн суртал зэрэг олон талаар монголтой нангиадаас хэдэн хувь илүүтэй ойр холбоо харилцаатай байж ирсэн аж.¹⁷ Эрдэнэ багшийн үйл хэргийг

¹⁰ 1590 онд Нурхачи 100 гаруй доод тушаалт жүрчин овгийн ахлагчдыг удирдан Бээжинд алба хүргэж байсан. Франц Михайл 1965,

¹¹ Хюммел 1964, 594-595-р талд үзнэ үү.

¹² Нурхачи монгол төрийн уламжлалаас үлгэрлэж байсны нэг илрэл нь эрдэмтэн зөвлөхөө “багш”, “заргач” тушаалд авсан явдал юм. Хубилай хаан 1270 онд Пагва ламыг “улсын багш”-аар өргөснөөс хойш, Өлзийт хааны Жамьянринчинжалсан багш, Хүлүг хааны Чойжи-Одсэр багш зэргээр бүхий л хаад өөр өөрийн “багш”-тай байж ирсэн нь Өгөөдэй хааны гутгаар хөвгүүн Годан ноён 1240 онд Саж бандида Гунгаажалцаныг залснаас эхтэй. Ахиулбал, “*дэлхий дахиныг морин дээрээс дагуулж болмуй, морин дээрээс засаж үл болмуй*” (天下雖得之馬上, 不可以馬上治) хэмээн зөвлөж асан хяганы Елүй Чүцайг Чингис хаан шадар зөвлөхөөр байлгасан түүхэнд ч хүрнэ. Их Монгол улс гүр иргэний зарга шийтгэх Шихихутаг “заргач”-тай байв. “*Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал*”, 30 боть, 2006-г үзнэ үү.

¹³ Петер Пердү (P. Perdue) 2005, 111 дүгээр талд үзнэ үү.

¹⁴ Шулуун шарын Нара овгийн Эрдэнийн өвгөдийн нутаг нь Дүенгэ. “ДБҮД”-нд “*Эрдэнэ багш, уг Хада хүн бөлгөө. 21 насанд Гэгээн хааныг эрж ирэв. Хаан ойр тэжээж бичгийн явдлын яаманд зарж үзэж тодорхой цэцэн болох тулд хожим өргөж фүжисань болгож тэжээсэн бөлгөө. Өчүүхэн үйлийн учирт нөхөр эхнэрийг цөм алав*” хэмээжээ. Тэр бээр 1623 онд тана сувд алт дарсан хэргийн улмаас эхнэрийн хамт цаазлагдсан. Роберт Окснам (Robert Oxnam), Хэтү ала-гийн баруун хойд дахь Дүенгэ тосгон өмнөд Манжуурын талын хятадууд болон Манжуурын баруунтаах монгол овог аймгуудтай тун ойр оршдог учраас Эрдэнийн хятад, монгол хэлний мэдлэг хөгжсөн болов уу гэжээ. Зарим нь монгол хүн гэдэг. 1654 онд Эээр засагчийн үед “*Вэньчэн*” (*wen cheng* 文成, мо. соёлыг бүтээгч) нэр нэхэж шагнав. ДБҮД III, 1561-1573; Хюммел 1964, 225-226; Окснам 1975, 18 дугаар талд үзнэ үү.

¹⁵ ДБҮД III, 1571 дугаар талд үзнэ үү. Ma. *ejehe dangse*, мо. *Ойллого данс*, хя. 舊滿洲檔 гэх энэ дансыг Тэнгэрийн тэтгэсний үед өгсөн “*Дусал бинтгүй үсгийн данс*” нэрээр хэрэглэж, “ДБҮД” гэж товчлов.

¹⁶ Kotwicz 1938, pp. 91-102, Ligeti Louis, 1960, pp. 231-248, Го. Миждиддорж, 1964, 127-186, William Rozycki 1994, Дагула 2006, 160-170 дугаар талаас цааш тодруулан үзнэ үү.

¹⁷ Ц. Шагдарсүрэн 2001, 263-265 дугаар тал; М. Баярсайхан 2007, 155-170 дугаар талд үзнэ үү.

1632 онд Нурхачийн хөвгүүн Абахайн зарлигаар Дахай¹⁸ дусал бинт нэмж, манж бичгийн хэлийг тогтолцоонд оруулж, монгол уламжлалаар 12 ангилж, зарим гадаад үсэг тэмдэглэх тэмдэгт зохиох зэргээр боловсруулснаар манж бичиг улсын бичгийн үүргийг гүйцэтгэх хэмжээнд хүрчээ. Манжийн хаад “Улс хөгжсн мандахад Эрдэнэ багш, Дахай багш дэс дэс гарч ирэв. Хоёр мөн бичгийн журамд нэгэн улсын чинээнд гарсан мэргэд бөлгөө”¹⁹ хэмээн үнэлж байв. М. Баярсайхан “зөвхөн бичиг үсэг төдий бус, ерөөс манжийн утга зохиол монгол хэл бичгээрх албан бичгийн зүйлээс эхэлсэн уламжлалтай байна. Манж нарын хэлбичгийн анхны багш нар нь монголчууд байсан тухайд маргах зүйл үгүй биз ээ”²⁰ хэмээжээ. Манжийн Тайзү (хя. *taizu* 太祖) дэлхийн талыг эрхшээсэн “Монголын Эзэнт гүрэн”-ээс бүхий л байдлаар суралцаж байсны жишээг бичиг үсгийн талаас мөн харж болно.

Пердү “Монголчуудаас манж нарт өгсөн хамгийн том бэлэг бол мэдээж монгол бичиг юм” гэжээ.²¹ Тэгвэл энэхүү бэлэг зөвхөн бичиг үсэг байсангүй, бичгийн соёлыг хамтатгасан гэж хэлж бүрэн болно. М. Баярсайхан монгол албан бичгийн уламжлалд хүндэтгэлийн утга илэрхийлэхийг 1. үгийн байршил орноор 2. бичгийн тиг хэлбэрээр 3. эд хэрэглэлээр 4. үг хэлээр 5. бусад хэмээн ангилж, орноор илэрхийлэхэд мөр тэтгэх, мөр дарах, мөр дашлуулах, шинэ мөрөөс эхлэх, мөрийн эхэнд үл бичих, зай авахыг багтаан, үг хэлээр илэрхийлэхийг нэр хураангуйлан бичих, үгийн сангийн аргаар, хэлзүйн аргаар хэмээн ангилан тус бүрчлэн үзсэн байна.²² Манж албан бичигт хүндэтгэл илэрхийлэх ёс нь үүнтэй нийлэх бөгөөд бичгийн хөгжлийн эхэн үедээ монголоос үлгэрлээд, Чин улсыг байгуулснаас хойш олон соёлыг шингээсэн дэг жаягаар хөгжиж, журам зүйлийг боловсруулан гаргасан нь төрийн нэгэн захиргаатайн улмаас эргээд монгол албан бичигт нөлөөлсөн зүйл ажиглагддаг.

Хүндэтгэлийн энэхүү нийдэм ёсыг *хааны жишээн дээр* манж баримтуудад тулгуурлан,

1. Гадаад хэлбэрээр
2. Дотоод агуулгаар
3. Орчин нөхцөлөөр хүндэтгэх гэсэн 3 үндсэн зүйлээр авч үзье.

1. Гадаад хэлбэрээр хүндэтгэх ёсонд хүндэтгэлийн орноор, бичгийн тиг хэлбэрээр, бичгийн эд хэрэглэлээр хүндэтгэхийг багтааж байна.

1.1. *Хүндэтгэлийн орон буюу үгийн байршилаар хүндэтгэх ёс.* Монгол албан бичгийн хамгийн дээд хүндэтгэл нь тухайн үгийг бичиг эхлэх ерийн мөр буюу дээд тараас тэтгэн бичих

¹⁸ Шулуун хөхийн хошууны Дахай нь Гиолча дахь гэр бүлээс гаралтай. 9 наснаас хятад хэл сурч, бичгийн эрдэмд боловсроод төрд зүтгэсэн. 1629, 1630 онд Манжийн довтолгоо Бээжинд хүрэхэд хятад хэлээрх бичгийг хариуцаж байв. 1630 онд үе дамжих дэд зэрэг авсан нь ийн хүндлэгдсэн анхны цэргийн бус хүн байж, дараа жил “багш” болов. 1632 онд 38 насандаа нас баржээ. 1636 онд “Вэньчэн” (хя. *wencheng* 文成, мо. соёлыг бүтээгч) нэр нэхэн өргөв. “ДБҮД”-нд: “Урьд Тайзугаас Цэцэн хааны 6-р он хүртэл хятад солонгосын бичгийн журганд зарагдав. Бичигт ихэд шоо (мо. яруу). Сэтгэл намхон, дотор цэцэн бөлгөө. Өвчин хүндэрсэн хойно, хаан өөрийн ойр сайдыг ирнэ үү хэмээж нүдний нулимс унаган өгүүллрүүн: Би Дахайг төрөөр өвдөх буй за хэмээн санав. Эдүгээ болохгүй хэмээх. Ихэд өршөөж завдсангүй. Хожим хөвүүдийг өршөөсүү. Та нар одоо үг өгүүл хэмээн 1 сувд 2 торго өгч илгээв. Зарсан хүн Хааны тэр үгийг хэлмэгч, Дахай багш дотор ухааж сэтгэл эвдэн уйлав. Өвчин хэтэрч үг өгүүлж чадсангүй... Дахай багш эртний үе үеийн зохиосон хятад бичиг хуулийг манж хэлээр орчуулган бичиж улсад тархааж, Манж улс эртний хэв хууль төр журам сонсоогүй мэдээгүй үгийг түүнээс ухааж үүсгэв” хэмээснээс хаанд шадар, улсад эрхэм хүн байсан нь илэрхий. Түүнийг нас барсанд 800-гаад цаас, 1 хонь, 2 малуу архи өгч илгээжээ. Урьд ийм ёс үгүй, үүнээс үүсгэв. Хаан, 3 хүүг нь шагнаж, дунд хүү Чэндэйг хятад бичиг сурахыг даалгаснаас, бичгийн эрдмийг залган хэрэглэх санаа харагдана. Хюммел 1964, 213-214; ДБҮД, VII, 3828-3830, X, 4643 дугаар талд үзнэ үү.

¹⁹ ДБҮД VII, 3830-р талд үзнэ үү.

²⁰ М. Баярсайхан 2007, 157-р талд үзнэ үү.

²¹ Пердү 2005, 111 дүгээр талд үзнэ үү.

²² М. Баярсайхан, 2010, 133-151 дүгээр талд үзнэ үү.

билээ. Үүнийг одоогоор мэдэгдэж буй монгол бичгийн эртний дурсгал болох 1224/25 оны Есүнгэгийн чулууны бичээсээс эхлэн монголчуудын алба, амины олон зүйл, монгол, тод, дөрвөлжин гэхчлэн олон бичгийн дурсгалаас төвөггүй үзэж болно. Уг бичээс “Чингисийн чулууны” хэмээн алдаршсан нь бичгийг харуут нүднээ содон тусгах энэ ёсноос үүдэлтэй.

1.1.1. Манжийн тухайд, хаанд өргөсөн бичгийн анхны хүндлэл нь *зай авч хүндэтгэх ёс* аж. Энэ нь хүндэтгэвэл зохих үгийн өмнө тодорхой хэмжээний зай үлдээхийг хэлнэ. Монгол албан бичгийн тухайд, Жан Ин шүйн хөшөөний бичээс (1335), Жигүнтэйн хөшөө (1338), “Сам жөн до”-гийн гэрэлт хөшөөнд (1639) буй.²³ Манж бичгийн хамгийн эртний дурсгал болох “ДБҮД” -нд энэ ёсыг чанд баримталжээ. Ингэхдээ:

- *Хаан өгүүрүүн, хаан суув, хаанд мөргөв, хаан сонсож* гэхчлэн хааны аливаа үйл хөдлөл, хааны сэтгэл, хааны их төр, хааны бичиг, хааны хөвгүүн, охин зэрэг бүх “хаан”-д хамаат зүйлд, *Дээд эзэн [зай] хаан, Цэцэн [зай] хаан, Гэгээн [зай] хаан,*²⁴ *Хятадын [зай] хаан, Эцэг [за’и] хаан* гэх мэтээр өмнөө тодотголтой тохиолдолд зэргээр ерөөс “han” (мо. *хаан*) гэсэн үг бичих бүрт өмнө нь зай авсан байна. Мөн [зай] *Цэцэн хаан* зэргээр нэр цолыг хамтад нь хүндэтгэх буюу [зай] *Цэцэн хүндлэн [зай] хаан*²⁵ зэргээр хослуулан давхар хүндэтгэсэн байдал ч бий.
- Хэрвээ “*хаан*” гэсэн үгийн өмнө зай авахад мөрийн төгсгөл орчимд тохиовол мөрөө дутуу орхиж шинэ мөрөөс эхэлнэ.

1-р зураг

ДБҮД, I:52	ДБҮД, I:58-59	ДБҮД, I:142	ДБҮД, I:139	ДБҮД, X:5325	ДБҮД, X:5325

²³ Dobu 1983, 212-269 дүгээр тал; М. Баярсайхан 2010, 137 дугаар талд үзнэ үү. Сам жөн догийн гэрэлт хөшөөний уг нэр нь “*Daechong hwangje gongdeokbi*” (ма. *Daicing gurun-i Enduringge Han-i gung erdemui bei*, мо. *Dayicing ulus-un Boyda Qayan-u erdem hilig-i dayurisqaysan bei*, хя. 大清皇帝功德碑). 1639 онд Жусон улс дагасны дараа Манжийн хаанд босгосон тул зай авч хүндэтгэх нь зүйн хэрэг.

²⁴ Нурхачийн “*Олон улсыг тэжээх Гэгээн хаан*” (ма. *geren gurun-be ujire genggiyen han*) цолоос үүдсэн.

²⁵ 1605 онд Энгэдэр тайж тэргүүтний өргөсөн цол. М. Баярсайхан 2007, 157, 8 дугаар зүүлт үзнэ үү.

Эхний баримтаас багахан зай авсныг, 2 дахь баримт мөрийн дунд зай аваад үгээ бичихэд хангалттай тохиолдолд үргэлжлүүлэн бичих болон мөрийн төгсгөлд тохиоход шинэ мөрөөс дээд тард бичихийг, 3 дахь баримтад зай авах журмыг мартагдан “с” үсэг тавьж зангасан байдлыг харуулж байна. Ийм зангасан зүйл тус дансанд тун цөөн аж. 4 дэх баримтад, “*sooha*” (мо. *цэрэг*) гэсэн үгийн өмнө бас зай харагдаж байгаа ч, үг нь хүндэтгэвэл зохих үгийн тоонд багтахгүй учир бичвэр баларсныг харуулна. Тиймээс сул зай бүхэн хүндэтгэлийн утгатай бусыг болзохгүй байж болохгүй. Харин зайн хэмжээ тус дансны эхний дэвтрүүдэд харилцан адилгүй, заримдаа зай төдий авч байх бол 5 дахь баримтад үзүүлчсэнлэн хойших дэвтрүүдэд улам бүр илт үзэгдэхүйц их зай авах болсон нь тогтворжсоны илрэл биз ээ.

“Хаан” улсын дээд хүмүүн бол, түүнээс дээш хүндлэл манж албан бичигт бий юу? гэдэг асуудал гарч ирнэ. “ДБҮД”-ны эхний дэвтрүүдэд “han” (мо. *хаан*), “abqa” (мо. *тэнгэр*), “fucihi” (мо. *бурхан*) гэсэн үгийг дээрх зарчмаар “хаан”-тай эн тэнцүү хүндэд эрхэмлэжээ. “Бурхан” гэсэн үг “тэнгэр”-тэй харьцуулбал цөөн тохиолдоно. Эдгээр нь манж угсаатны соёл шүтлэгийн асуудалтай шууд холбоотой. Манж нар язгуураас тэнгэрийг шүтсэн бөөгийн шашинтай тул “тэнгэр”-“хаан” хоёул эрхэм юм.(1.1.4-т дэлгэрүүлнэ). Жич, “*amba jui*” (мо. *их хөвгүүн*) гэх мэт өөр үгийн өмнө зай авсан зүйл мэр сэр тохиолдож буйг бичээчийн санамсаргүйгээс үүдсэн гэлтэй. Учир нь тухайн үгийг тэрхүү ганц нэгээс үед тогтмол зайгүй бичсэн аж. Бас, “han” гэдэг үгийн өмнө зай аваагүй байдал ч цөөн хэдэн газарт бий.²⁶

Тулгар байгуулсан улсад аливаа хууль дүрмийг явцын дунд шинээр боловсруулан гаргаж журамлаж байснаас, “ДБҮД”-ны сүүлийн дэвтрүүдэд зай авч хүндэтгэх үгийн тоо нэмэгджээ. Бидний авч үзэж буй “хаан”-ы жишээнд гэхэд, 1-р зургийн 5 дахь баримтад буй “*enduringge*” (мо. *богд*) хэмээх үгийн өмнө зай авч хүндэтгэсэн нь 1636 оноос Хаанд²⁷ *их нэр* (ма. *amba gebu*) өргөсөнтэй холбоотой. Энэ нь “*авсуу, өгсүү*” хэмээхийн дураар болдог хэрэг бус юм. Тодруулбал, “*олон бэйс амбас зөвлөн тогтоож, хууль тэмдэглэх бичгийн яамны Хифа, Гарин, нарийн бичгийн яамны Лошо, Ёслолын явдлын яамны Кичүнгэг зарж, Хаанд үг айлтгаж огуулрүүн: Өнгөрсөн жил нэг зэрэг Дотоод гадаад бэйс хаанд үг айлтган, Күн, Ган, Шан 3 жсанжсин дагаж ирэв. Бас монголын Цахар улс дагав. Гадаад улсыг бүгд болгов. Хаанд их нэрийг өргөн дуудсуу хэмээвээс, Хаан: Тэнгэрийн байдлыг үзэлгүй их нэрийг хүлээн авбаас болохгүй. Тэнгэр оршоож газар орныг олов. Их төрийг бүтээх учир болбоос тэр үед их нэрийг авбаас удахгүй болой хэмээн цааргалан болсонгүй бөлгөө. Эдүгээ Цахар хааны хөвгүүн тайж, улс иргэн бүрэн дагав. Бас эртний үе үеийн хаадын тэмцсэн хас эрдэнийн тамгыг²⁸ олов. ...Эдүгээ тэнгэрийн тэтгэхэд нийцүүлэн их нэрийг тогтоосугай хэмээн үг айлтгасан хойно, Хаан огуулрүүн: Эдүгээ хэдий тойрон улс олсон, хас эрдэнийн тамгыг олсон ч их төрийг бүрэн бүтээгээгүй” хэмээн хэдэнтээ татгалзаж, олон бэйс ахин дахин айлтгасанд, Хаан: “Энэ үг нэгэнтээ болбоос миний тулд, нэгэнтээ болбоос урьд хаан эцгийн тулгар байгуулсан улсын төрийн тулд болой. Сахалиян бэйл чи Ёслолын явдлын яамны бэйл. Хэлэлцнэ үү, үл хэлэлцнэ үү, чиний дур. Олон бэйс өөр өөрийн биеийг засан андгайлан барсан хойно, тэр үед их нэрийг хүлээн авах, авахгүйг би ухах хэмээн огуулэв.” Дараагаар Их бэйл*

²⁶ Мөн тэнд, I, 31, 40, 51, 73 дугаар талд үзнэ үү.

²⁷ Нурхачийн 8-р хөвгүүн, 4 их бэйлийн дөтгөөр нь болох сурвалжуудад Хунтайж (хя. *huang taiji* 皇太極) хэмээн тэмдэглэгдсэн Абахай (1592.11.28-1643.9.21) 1626 оны 10 сарын 20-нд Алтан улс (ма. *Aisin gurun*)-ын хаан ширээг залгамжилсан. Хюммел 1964, 1-3 дугаар тал.

²⁸ Энэ тухайд 1.3 дугаар хэсэгт тодруулан авч үзэх болно.

Дайшан, Абтай, Жаргалан, Ажигэ, Доргон, Додо, Дүдү, Ёто, Хоогэ, Сахалиян андгайлсанд, Хаан “*ах дүү хэмээсэн Солонгосын ванд сонгосуу*” хэмээн элч илгээжээ. Ийнхүү зөвшлөг, ятгалга, татгалзлын эцэст хааны өөрийнх нь болоод тэргүүлэх ноёд, хөрш улсын санаа савд Тайзү Нурхачийн үлдээсэн жүрчиний Алтан улсыг манжийн Чин улс болгон тохинуулан тогтнуулснаа хүлээн зөвшөөрөх хэмжээнд хүрсэн Цэцэн хааны 10-р он (ма. *sure han*, хя. *tian cong* 天聰) 3 сарын 12-нд сая “*Өршөөл агуу найралт богд хаан*”²⁹ хэмээх их нэр авч, олон сайдыг авч Тайзү, Тайху³⁰, өвгөдийн сүмд тайн, 13-нд *Богд хаан* (ма. *enduringge han*) “*их сууринаа суусан ёсоор их хурим хуримлаж, жуу бичиг дуудаж иргэнийг сурган, сиеэ бичиг буулгаж ялт хүний ял гэв.*”³¹

Үүнээс хойш “*enduringge*” гэсэн үгийн өмнө зай авч хүндэтгэх болов. Энэ зай Абахайн 10 жилийн үйл хэрэг, Өвөр монголын болон Солонгосын газар нутагтай тэнцэнэ.

Цэцэн хааны 9-р онд Хаан “*Манай улсын нэр угаас Манж.*”³² *Хада, Ула, Ехэ, Хойфа болой. Түүнийг ухахгүй хүн жүрчин хэмээгүй. Жүрчин хэмээх нь Шивээгийн Чуу мэргэний удам болой. Тэр бидэнд юун хамаа. Үүнээс өмнөш*”³³ аливаа хүн манай улсын уг манж хэмээх нэрийг унш. *Жүрчин хэмээн уншсанд ял*”³⁴ хэмээн зарлиг буулгаж (“ДБҮД”-нд Алтан улс гэж бичсэнийг “Манж” болгон зассан зүйл олон. 3-р зураг), улсын нэрийг Их Чин хэмээж, 10-р онд “Богд хаан” өргөмжлөгдсөнөөс хойш зай авч хүндэтгэхэд хааны эцэг эх “*Taizu, Taiheu*”-ээс эхлэн, “*γosin ončo, huwalyasun, enduringge*” залган, хааныг заасан “*bi, mini, minde, timbe*” (мо. би, миний, надад, намайг) зэрэг төлөөний үгс хүртэл хамрах болжээ. (4-р зураг)

²⁹ Ма. “*γosin ončo huwalyasun enduringge han*” хэмээсэн цолыг үгчлэн орчуулах аваас ийм бөгөөд монгол тогтсон орчуулга нь мо. “*Агууд өршөөгч найрамдуу богд хаан*” хэмээнэ.

³⁰ Хунтайжийн эх Ехэ аймгийн ахлагч Янгинүгийн бага охин Мүнгү (хя. 孟古 1575-1603) ба нэхэн өргөмжилсөн нэр нь “*Сяо ци*” (хя. *xiaoci gao huang hou* 孝慈高皇后). Хюммел 1964, 1-3 дугаар тал.

³¹ ДБҮД, IX, 4587 - X:4738 дугаар талд үзнэ үү.

³² Манж хэмээх нэрийн утга, гарлын талаар нэгдсэн саналд хүрээгүй байна. Росс, Манж, Чин (清) хоёулаа “*усны тунгалаг*”, Мин (明)-гийн “*тод гэрэл*” буюу нарны тунгалагас улбаалсан гээд, Хятадын хаант улсуудын нэр бие биеэсээ авсан бололтой (Ляо улс “*Төлөр*”, Жинь улс “*Алт*”, Юань буюу “*Жинхэнэ уг*” гэдэг Мүнгүү (хя. *teng gi* 蒙古)-г “*Мөнгө*”) гэсэн буй. Солонгос сурвалжид “ман”- жүрчиний “10000”, “жу”- үргэлжид мандах, Широкогорофф “*нэгдсэн мужууд*”, Стари “ман”- *их, хүчтэй*, “жү”- *бүтэхийг ерөөсөн*, Нин “*бүдүүлж эзэн*”, Мэн сэн “*их удирдагч*”, Чингийн албан бичигт “*Манзуишири*” бурхантай, хятад түүхэнд “*бүгд гахайс*” гэх домогтой холбож, Хуан Чан сень Жяньжоу жүрчиний төвлөсөн газрын нэрээс үүтгэж, Амур голын нэрээс эхтэйг Цинциус дэмжиж, Хауэр Ли ман жу гэх хүний нэр, Широкогорофф “*судаар баян*”, сүүлийн үед Хуан “*jusen*”-ний “*овгийн эзэн*” гэсэн утгатай холбож үзжээ. Росс 1973, 7, 515, Хуан (Pei Huang) 1990, 239-282 дугаар талд үзнэ үү.

³³ “*ereci Julesi*” гэдгийг үгчлэн орчуулбал мо. “*үүнээс өмнө*” гэнэ. Утгын хувьд, монголоор яг эсрэг “*үүнээс хойш*” гэсэн санаа илэрхийлнэ. Манж сэтгэхүйгээр ирээдүй цагийг өмнөө байгаагаар ухаарч надаас өмнө - “*үүнээс өмнө*” гэж хэлдэг. Монгол хүн эзэн бие нь эхэнд байж, надаас хойш - “*үүнээс хойш*” гэнэ. Манж аман зохиолд, “*Ло хан ван бас өмнөш гүйн одов.*”, “*Нью дань удган хурдан өмнөш явруун*” хэмээдэг нь дээрх сэтгэлгээний жишээ ба мо. “*цааш*”-тай дүйнэ. 愛新 覺羅 1987, 44, 94 дүгээр талд үзнэ үү. “*Гаозүн бүрдэлт хуандийн богд сургаал*” 122-р дэвтэрт, “*Дээд эсрлиг буулгасан нь, үүнээс өмнө намайг дагалдуулан гаргасан Ёс заах яамны түшмэлд эрхгүй хичээнгүйлэн болгоомжлон яв*” хэмээн “*хойших*” түшмэлд ухуулжээ. Я. Шаарийбуу 1990, 127 дугаар талд үзнэ үү. Манж албан бичигт энэ мэт сэтгэхүйн онцлогийг анхаарахгүй бол бичвэрийн утгыг эсрэгээр ойлгох, орчуулахад хүрэх гэмтэй. Манжид “*ereci Julesi*”-ээс гадна бас “*ereci amasi*” (үгчилбэл, үүнээс хойш) гэнэ. “ДБҮД”-нд хоёуланг хэрэглэжээ. “*ereci Julesi*” нь уугал сэтгэхүйг тусгасан арай эртний хэллэг юм.







³⁴ ДБҮД IX, 4509 дүгээр талд үзнэ үү.

1.1.2. Монгол бичиг, дөрвөлжин бичгээрх дурсгалд түгээмэл байдаг *шинэ мөрөөс эхэлж* хүндэтгэх ёс манж албан бичигт бас бий. Хүндэтгэх үг буюу хэсгийн араас бичвэрийг шууд бус, шинэ мөрөөс үргэлжлүүлэхийг хэлнэ. Дараах тохиолдолд ийм аргыг хэрэглэнэ.

- Хүндэтгэвэл зохих үгийн өмнө зай авахад мөрийн төгсгөл орчимд тохиох буюу багтахааргүй бол мөрөө дутуу орхиж шинэ мөрөөс эхэлнэ. Энэ нь дээр өгүүлсэн зай авах ёсноос шууд үүдэлтэй. (1-р зургийн 2 дахь баримтыг үзнэ үү.)
- Хааны үг, зарлиг “*seme henduhe*” (мо. *хэмээн өгүүлэв*) гэж дууссан тохиолдолд шууд шинэ мөрөөс эхэлнэ. (5-р зураг)

1.1.3. *Мөр дарж хүндэтгэх ёс* манж албан бичгийн эхэн үеийн баримтуудад төдийлөн харагдахгүй бол манж бичигт дусал бинт тавьж, амьдралын шаардлагаас үүдсэн бичгийн дүрмүүдийг оруулж, албан бичиг боловсрон хэв маягаа олсноос хойш тогтсон байна. Үүнд:

- Албан бичгийг илгээж буй хүн өөрийн нэрийг дарж бичнэ. (6-р зураг)
- Албан бичгийг бичих, тамга дарах зэргээр шийтгэсэн хүн нэр тушаалаа мөрийн тэхий дундаас дарж бичнэ. (7-р зураг)

3-р зураг	4-р зураг	5-р зураг	6-р зураг	7-р зураг	
					
ДБУД, VIII:3804	ДБУД, I:99	ДБУД, X:4740	ДБУД, I:57	MI-DI: 1918	MI-DI: 1266

1.1.4. *Мөр тэтгэн хүндэтгэх ёс*. Манж албан бичигт мөр тэтгэх ёс хэрхэн тогтсон байдлыг “ДБУД”-ны 10 дэвтэр дотроос нь харж болно. Энэ баримтаар, лавтай гурван шатаар хөгжжээ.


- Анхандаа “*хаан*” хэмээх үг зөвхөн мөрийн сүүлд тохиоход өргөнө. Зарим үед илэрхий онцлох бус ердөө “*өргөсөн маягтай*” ч бас үзэгддэг.
- Дараагаар нь “*хаан*” хэмээх үгээ *их нэр* гэх зэрэг тодотголынх нь хамтаар мөр тэтгэх

болов. Үүнд, тэтгэсэн үгсийг ерийн бичвэрээс гойд өргөх болсон. Эхний хоёр тохиолдолд хүндэтгэсэн үгсийг мөр тэтгээд, хойноос эх бичвэр залган үргэлжилнэ.

- Тухайн үгийг мөр тэтгэхийн хамтаар, дангаар нь бүтэн мөр эзлүүлж, залгах бичвэрийг дараагийн шинэ мөрөөс эхлүүлнэ. Энэ нь өмнө өгүүлсэн зай авах, шинэ мөрөөс эхлэх болон мөр тэтгэхийг бүхэлд нь агуулсан чухам дээд бүрэн хүндлэл юм.

Чингийн анхны хаан бичигт тэмдэглэсэн үгийн байршил тухайн хүн буюу улсын зэрэг зиндааг тодорхойлдгийг ялгамжаатай ашиглаж байжээ. Тэр бээр “Бичгийн үсгийг дээр доорыг түр бүү хэлэлцэгтүн. Хэрэг урьдаар бүтээ. Хэрэг бүтсэн хойно, Их улсаас чингээж дараалуулбаас намайг Цахараас дээр үзвээс зохимуй”³⁵ хэмээсэн буй. Түүний хэрэг хэрхэн бүтсэнийг мөр тэтгэсэн жишээгээр ажиглавал сонирхолтой болов уу.

8-р зураг



Цэцэн хааны 3-р онд Мин улсын сайд нарт бичиг илгээх үед болон тэр үед Их Мин улсын хуандид бичиг барих үед (эхний хоёр баримтын зураг) бичгийн агуулга дотроо ч “манай бага улс” хэмээн бичиж, тэдний улсыг хол дээр тэтгэж, дээр нь “тэнгэр” (ма. *abqa*)-ээ залж байсан бол 10-р онд хоёр улсын нэр зэргэлдээ түвшинд очиж, Мин улсын Гинжү мужид дайлаар мордсоноос хойш “Даймин” гэсэн нэрийн “Дай” (хя. *dai* 大 мо. *ix*) гэсэн үсгийг зурагт үзүүлсэнчлэн нэлээд олон газар дарж балласан нь энэ улс тэдний хувьд “их” байхаа больсны илрэл бөгөөд Дээд эрдэмтийн анхдугаар он 9 сарын 28-нд Минг дайлаар одсон төрийн Баатар жүн ван, төрийн Баян бэйл нарын цэргийг Хаан Мүгдэн хотоос гарч өөрийн биеэр угтаж, ялж олсон бичгийг хүлээн авч, хол газар бие зовж, царай ядсаныг үзэн Богд хаан нулимс унаган, тэврэн золгосноос хойш Дайчин улс Даймингээс дээр тэтгэгдэх болжээ.

Ийнхүү хааны эрх хэмжээ бичигт ч бүрэн хүндлэлийн 2 буюу 3 зэрэгт мөр тэтгэгдэх болов.

³⁵ ДБУД VIII, 3795.

“Дайчин улсын бүгд хууль”-д³⁶ гутгаар зэрэгт мөр тэтгэх үгс:

- улс гэрийн зүйл: gurun-i gebu (улсын нэр), gurun-i suduri (улсын судар) г.м.
- хаанаас дооших хааны хамаат хүний зүйл: hūwang taizi (хунтайж), hūwang gui fei (хуан гүйфэй), gui fei (гүй фэй), fei (фэй), г.м.
- хааны засаг захиргааны зүйл: dorgi baita-be uheri qadalara yamun (дотоод хэргийг бүгд захирах яам), dorgi ba (дотоод газар), giyangnara ba (тайлбарлах газар) г.м.
- хааны орд харш, орны зүйл: abqai elhe obure duqa (Тэнгэрийн амгалан болгох хаалга), amba dasan-i diyan (их засгийн дянь), amba hūwaliyambure diyan (Их найралдуулах дянь), daičing duqa (Дайчин хаалга), enteheme hūwaliyambure diyan (Ашид найралдуулах дянь), julergi dulimba duqa (Өмнөд дундадын хаалга) г.м.
- хаанд үйлчлэх үйл хэргийн зүйл: ambarame giyangnara (ихэд тайлбарлах нь), inenggidari giyangnara (өдөр бүр тайлбарлах), dolo benembi (дотор хүргэмүй), ilire tere-be temgetulere (босох суухыг тэмдэглэх), urgun-i dorо (баярын ёс) г.м.
- хааны нэр цол, үйлийн тодотгол: geren irgen-be hūwadabume ujifi (олон иргэнийг хүмүүжүүлэн тэжээж), eldehe inenggi (гийсэн өдөр)³⁷ г.м.
- хааны эдлэл хэрэглэлийн зүйл: biyoo bidhe (бяо бичиг), boobai dere (тамгын ширээ), suwayan kiyoо (шар сүйх) г.м.

Хоёрдугаар зэрэгт мөр тэтгэх үгс:

- эцэг өвгөдийн хамаат дэд хүндлэлийн зүйл: yolmin šanyan alin (Урт цагаан уул)³⁸, hansai mungyan (хаадын онгон),
- хааны хийх, шийтгэхэд хамаат үйл хэргийн зүйл: hūwangdi (хуанди), hūwangdi-de urgun-i dorоi (хуандид баярын ёсоор), šohotome (тусгайлан), dele baičame yabure (дээр байцаан явах), dergiči toytobufi (дээрээс тогтоож), donjibume wesimbumbi (сонсгон айлтгамуй), hese-be baime (зарлигийг эрж), hese-be dahame gisureme (зарлигийн даган хэлэлцэж), hesei (зарлигаар), hese wasimbuhangge (зарлиг буулгасан нь), tučime yabure (гарч явах), tuwabume wesimbufi (үзүүлэн айлтгаж),
- хааны эд хэрэглэл, бичиг зарлиг: boobai (эрдэнэ), boobai dere (эрдэнийн ширээ), še, g'aoming (чэ, гаомин³⁹), wesihun hese (дээд зарлиг), жоо bidhe⁴⁰ (жюу бичиг),
- хаантай ижил зэргэдийн ургийн зүйл: hūwangheu (хуанхэу) г.м.

Тэргүүн зэрэгт мөр тэтгэх үгс:

- тэнгэр, газрын хамаат зүйл: abqa (тэнгэр), na (газар),
- тайх шүтээний зүйл: taimiyoo (таймяо), miyoo (мяо), abqai tan (тэнгэрийн тань), na-i tan (газрын тань), mungyan (онгон) г.м.
- эцэг дээдсийн зүйл: taizu (тайзү), šengzu yosin hūwangdi (шэнзү оршоол хуанди), šizu eldeldembuhe hūwangdi (шизү гэрэлт хуанди), tai hūwangtaiheu (тай хуантайхэу), taizung genggiyen du hūwangdi (тайзүн гэгээн шү хуанди), hūwangtaiheu (хуантайхэу),

³⁶ ма. Daičing gurun-i uheri qooli bidhe, мо. Дайчин улсын бүгд хууль бичиг хэмээх Найралт төвийн 10-р онд (1732) бичиж төгсгөсөн тус хуулийг цаашид “Бүгд хууль” гэнэ.

³⁷ Үгчилбэл, “гэрэлтсэн өдөр” боловч монгол тогтсон орчуулга нь “гийсэн өдөр” гэнэ.

³⁸ “Урт цагаан уул” нь Манж нарын өвөг дээдсийн унаган нутгийн нэр тул хүндэтгэнэ.

³⁹ Хя. gao ming 浩命, ма. ulhibure fungnehen, мо. ухуулах өргөмжлөл. “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгийн толь бичиг”-ийн 3-р дэвтэрт “Тавдугаар зэргээс дээш түшмэдийг өргөмжлөх бичиг” гэжээ.

⁴⁰ Хя. zhao, ма. жоо, мо. жиу. Хааны зарлигийн бичгийн хүндэтгэл нэр болно.

- хааны хамаат зүйл: enduringge (богд), han (хаан), beye (бие), han-i soorin (хааны суурин), hese (зарлиг), yargiyan qooli (магад хууль) dergi čolo (дээд цол), жоо bidhe (жуу бичиг), kesi (хишиг), šangnaha (шагнасан), soorin (суурь) г.м.

Зарим тохиолдолд нэг үг тэргүүн болон дэд зэргийн аль алинд хамаарч буй нь бичгийн утга агуулгатай уялдах ажээ. Үүнд, хэрэв тэнгэр газар, эцэг өвгөдийн нэр зүйл бүхий бичиг бол эдгээрийг тэргүүн зэрэгт тэтгэж, “han” (мо. хаан)-ыг дэд зэрэгт тэтгэнэ. “Хаан”-аас дээш хүндэтгэх зүйл үгүй бол тэргүүн зэрэгт тэтгэнэ. Жишээ нь, “Шэнзү өршөөлт хуанди сууринаа суусан ёс”⁴¹-нд “...хаан сүйхэнд дэвшиж, Чянь чин мэнх хаалганы дундадын хаалганаас гарах бөлгөө. Зарлиг, ...би хэрхэн түвдээс Хаан эцгийн өмнө даруй сүйхнээ сууж Дундадын хаалганаас гарах буй. Зүүн этгээд хажуугийн хаалганаас гарч жич сүйх сууваас санаанд сая амар болмуй хэмээв.” Энд хаан эцгийн “хаан”-ыг тэргүүн тэтгэж, залгах “хаан”-ыг дэд зэрэгт мөр тэтгэсэн буй. Бас, Найралт төвийн анхдугаар он, “Өчигдөр гэнэт хуанлиг үзэхэд хоёр сарын улирлын хуудасны дотор Богдын нэрийн дээр нэгэн үсгийг үзсэний учир, тэсгэлгүй дуун гаран гашуудан уйлав”⁴² гэснээс энэ ёсыг хэрхэн эрхэмлэдгийг мэдэж болно.

Иргэний болон яамдын хаанд айлтгах бичгийг хуульчлан заасан буй. Үүнд, Найралт төвийн 3-р он, Ёслолын явдлын яамны бичиг 67-р дэвтрээс үзвэл, түшмэл, иргэн бичиг бичиж гарган айлтгахыг нь “зүү бэнх” гэнэ. Олон яамнаас албаны хэргийн тул айлтгахыг нь “ти бэнх” гэнэ. “Ти бэний дүрэм, хуудас бүрд 6 мөр, 1 мөрд 20 үсэг бичмүй. Гэзыгийн дотоодод өргөж бичсэн нь 2 үсэг, тэгш шугамд /neĭin jurgan/ бичсэн нь 18 үсэг, Гэзыгээс гарган өргөж бичвээс, 1 үсэг болгомуй. ...Зүү бэнх бичгийн дүрэм. Хуудас бүр 6 шугам, 1 мөрд 24 үсэг бичмүй. Гэзыгийн дотор өргөн бичих нь 2 үсэг, тэгш шугамд бичих нь 22 үсэг, гэзыгээс гарган өргөж бичвээс 1 үсэг болгомуй. ...Үүний тул хичээнгүйлэн сонсгож айлтгав (ма. erei jalin ginggulete donjibume wesimbuhe) хэмээн бичмүй. “Үүний тул” хэмээх үсгийг тэгш шугамд бичмүй. “Хичээнгүйлэн” хэмээх үсэг, “айлтгав” хэмээх үсгийг хоёр үсгийн газрыг харайж бичмүй.⁴³ “Сонсгомуй” хэмээх үсгийг хуудаснаас өргөн бичмүй” гэжээ.

Чингийн үеийн манж, монгол баримтуудад энэ мэт бичгийн дүрэм, тогтоосон ёсыг чанд баримталсан байдаг. Үүнд, abqa (тэнгэр), taizu (тайзү), han [tafa]⁴⁴ (хаан өвөг) болон урьд хаадын нэр цол зэрэг үгсийг дангаар нь мөр эзлүүлэн **бүтэн үгээр** тэтгэх; enduringge (богд), abqai [kesi] (тэнгэрийн хишиг), ten-i [dergi] (туйлын дээд), amba [enduringge] (их богд), dergi [abqa/hese] (дээд тэнгэр/зарлиг), dele [jafara] (дээр барих), hūwangheu (хуанху), ejen (эзэн), hūwangdi (хуанди), hese (зарлиг), donjibume (сонсон), elhe-be baime (амгаланг эрж), šang (шан), booi tačihayan (гэрийн суртал), aniyai doroī (цагаан сарын ёсоор) гэх мэт үгсийг дээд тарын дээд шугамаас дээш **дөрвөн үсгээр** тэтгэж; wesimbure (айлтгах), jafara (барих), fulgiyan fi-i pilehe (улаан бийрээр цохсон), aniyai idu (жилийн жасаа), gemun hecen (нийслэл хот), sirara (залгах), čohotoi (тусгайлан) зэрэг үгсийг **хоёр үсгээр** мөр тэтгэсэн байдаг. Хааны зарлигийг бичихдээ, “hese” (зарлиг) хэмээх үгийг тэргүүн зэрэг мөр тэтгээд, хойш хэдэн мөр

⁴¹ Бүгд хууль, 57-р дэвтэр, Ёслолын явдлын яамны зүйлд үзнэ үү.

⁴² Бүгд хууль, 67-р дэвтэр, Ёслолын явдлын яамны зүйлд үзнэ үү.

⁴³ Энд “харайн” гэсэн нь монголоор үгчлэн орчуулсан ба ерийн бичвэрийн эхэлбэл зохих шугамаас хоёр үсгийн зайд дээш өргөн бичихийг хэлнэ. Монгол хүн “өргөж” гэж хэлэх утгыг илэрхийлж буй манж сэтгэлгээг анзаарахын үүднээс үгчилсэн орчуулгаар тавив.

⁴⁴ Өмнөх үгийг дагалдан, хамтдаа тогтсон хэллэг болох үгийг [...] хаалтад бичив.

үргэлжилсэн ч бичвэрийг бүхэлд нь *хоёр үсгээр* тэтгэн бичнэ. Мөр тэтгэх хүндэтгэлийн орныг цаасны шугамаар тусгайлан гаргаж өгнө. (9-р зураг, эхний баримтыг үзнэ үү.)

Манж нар “*Тэнгэрийн гурван дагинын отгон охин Фэкүлэн улаан жимс хүртээж бие шалтагтай болон хөвүүн төрсөн*”-өөс Айсин гиоро овог эхэлсэн хэмээн өөрийн угсаа гарлыг тэнгэртэй холбодог⁴⁵, уламжлалт бөөгийн шүтлэгтэй тул тэдний хувьд хамгийн дээд нь “*Тэнгэр*” юм. Өмнө I.1.1-д дурдсанчлан, “*ДБҮД*”-нд *тэнгэр, бурханыг* өмнө нь зай авч, мөрийн төгсгөл орчим тохиоход мөр тэтгэх байдлаар “*хаан*”-тай эн тэнцүү хүндэлсэн байдал чанд үзэгдэнэ. Хойших үеийн баримтад “*хаан*”-аас дээш мөр тэтгэх буюу бүтэн мөр эзлүүлэн тэтгэх хүндлэлийг “*тэнгэр, өвгөд, тайзү, тайхуан тайхэү, хаан эцэг, богд хуанди, хуантайхэү, онгон, мяо, тан*” зэрэг хүлээх болжээ.

Тэнгэрийг эрхэмлэх үзлийг уг зарлигаас тодорхой мэдэж болно. Жишээ нь, “*Хаан гагцхүү өөрийн сэтгэлээс асууж Тэнгэрийн сэтгэлд нийлүүлэх нь болой. Тэнгэрийн сэтгэл хааны сэтгэл*”⁴⁶, “*Бид аливаа тэнгэрийг тэргүүндээ тавьж, аргаар бүү явагтун*”,⁴⁷ “*Хаан 3 явдлын яамны бичгийн хүнийг цөм хурааж өгүүллүүн: Би хятад бичгийг үзвээс хоосон худал үг ихэд. ...Жич хятад улсын хүн өөрийн хятад улсын эрдэмт хаан, ёсгүй хаадыг цөм нэгэн адил тэнгэрийн хөвгүүн хэмээжүхүй. Эрхгүй түүний тэнгэрийн хөвгүүнийг хэрхэн олж мэдмүй. Дэлхий дахин нэгэн хүний дэлхий дахин бус. Гагцхүү эрдэмт хүнд тогтмуу. Эрдэмт хүнийг тэнгэрийн хөвгүүн хэмээх буй за. Эдүгээ тэнгэр өршөөж намайг манай улсад эзэн болгосон бөлгөө. Би тэнгэрт хөвгүүн ураг удам болно уу? Сайн журмаар явахгүй, тэнгэрт нийцүүлэхгүй болбоос тэнгэр намайг буулгаж бусад сайныг улсад эзэн болговоос мөн тэнгэрийн дур болой хэмээн өгүүлэв*”⁴⁸ хэмээжээ. “*Таван хэлний толь*”-ийн Хааны зүйл ма.“*abqai jui*” (мо. тэнгэрийн хөвгүүн, хя. *tian zi* 天子) хэмээн эхэлж, цааш “*hiiwangdi*” (мо. хуанди, хя. *huang di* 皇帝), “*han*” (мо. хаан, хя. *jun* 君), “*ejen*” (мо. эзэн, хя. *zhu* 主) гэж дараалдаг нь тэнгэр-хаан хоёрын холбооны бас нэгэн илэрхийлэл юм.⁴⁹

⁴⁵ Фэкүлэний тухай Манжуурт хятадууд манж нарт алба хаахаар хойд зүгт одохдоо гэр орноо, бүх зүйлтэй нь, эмэгтэйчүүдээ ч орхиод явсан гэх энгийн түүх бий. Сийрүүлбэл, “...Ван гао бол энд алба хааж байсан Шаньдунгийн хүн. Зарим нь хүүхдийн эцэг, зарим нь Фэкүлүн болон хүүг харж хандаж байсан үнэнч зарц гэдэг. Ван гао нэг өдөр ердийнхөөрөө хүнс тэжээлд яваад эргэж ирээгүй аж. Эмэгтэй хүлээсээр, эцэст нь толгодын завсрын ангалд унаж, хүү тогсгоныхны тэжээвэр болжээ. Харин тосгон түүгээр дамжуулан хүн орхоодойгоор тэтгэгдсэн гэнэ. Энэ түүх зарим талаар Манжуур дахь олонд тархсан дараах 3 хэлцээр батлагдана. ‘*Pan ni xiang Wang Gao*’. (Чамайг Ван гаог хүлээсэн шиг л хүлээлээ), ‘*Xian ji Wang Gao, hou ji Baishan*. (Эхлээд Ван гаог, дараа нь Цагаан уулыг тахь), ‘*Xian Wan Gao, hou Huang lin*’ (Эхлээд Ван гао, дараа нь хааны бунхан). Зарим нь Айсин гиорог монгол оргодол байсан гэдэг. Росс, 1891, 4-5 дугаар талд үзнэ үү. Үнэхээр, угсаа гарлын домгийн хувилбаруудад Фэкүлэнийг хүүдээ самуун улсыг зас хэмээн сургаад өөрөө тэнгэрт дэвшсэн, эсвэл сагс хадаж хөвүүнээ “үхвээс үхтүгэй, тэнхэрвээс тэнхэртүгэй” хэмээн голд урсгасан гэх эерэг, сөрөг сэтгэгдэл төрүүлэхүйц өгүүлэмж, Ло хан вангийн орхоодойн арилжаа гардгийг үзвэл, домгийн хажууд бодит амьдралын үүтгэл сурвалж байх боломжтой санагдана. “*Дайчин улсын Тайзү богд хуандийн магад хууль*” дээд дэвтэр, 愛新 觉罗 1987-д үзнэ үү.

⁴⁶ ДБҮД, VIII, 3617 дугаар талд үзнэ үү.

⁴⁷ Мөн тэнд, VIII, 3607 дугаар талд үзнэ үү.

⁴⁸ Мөн тэнд, IX, 4270-4271 дүгээр талд үзнэ үү.

⁴⁹ *Han-i araha sunja hacin-i hergen qamcibuha manju gisun-i bidhe*, Хааны хураангуй, 1957, 252-254 дүгээр талд үзнэ үү.

Улсын заяа, хааны суудал бүгд тэнгэрээс шалтгаалах тул, баяр ёс алив бүхнийг юун түрүүнд тэнгэртээ мэдүүлж, тэнгэр тайх бичгийн үгийг тогтоон бичиж, хүнд ёслол үйлддэг, ёслолын үед хэн хаана байх орон, дэс дарааг нарийн тогтоодгийг “ДБҮД”, “Дайчин улсын бүгд хууль”-д дэлгэрэнгүй тэмдэглэсэн буй.⁵⁰ Мөнхүү улсыг байгуулсан, тохинуулсан, мандуулсан эцэг өвгөдийг тайх нь ачлал үзүүлэх магад журмын хэрэг билээ. (9-р зураг)

Харин мөр дашлуулах, мөрийн эхэнд үл бичих хүндэтгэлийн ёс хааны жишээнд илрэхгүй, “хаан”-аас дооших хүндэтгэлийн зүйлд хэрэглэгдэнэ. Үүний учир нь мэдээжээр “хаан” бол улсын дээд хүмүүн, түүнтэй ижил зэргийн хүн үгүйтэй холбоотой аж.

9-р зураг

<p>Дайчин улсын бүгд хуульд мөр тэтгэсэн нь</p>	<p>М1:Д1 3313-19</p>	<p>М1:Д1 2899-4</p>	<p>Найралт төвийн Энх-Амгаланд илгээсэн захидлаас⁵¹</p>

1.2. Бичгийн тиг хэлбэрээр хүндэтгэх ёс. Бичгийн хэв жигд хичээнгүй тигтэй, алдаагүй цэвэр нямбай байх нь хаанаа бичгээр хүндлэхийн нэгэн илэрхийлэл болно. Үүний зэрэгцээ хааны бообайн зүйлд тусгайлан тулгарын үсгийг хэрэглэнэ. Жишээ нь, Тэнгэрийн тэтгэсний “улирлыг бадруулах бообай” (ma. forγon-be badarambure boobai)-д “хасын зит тулгарын үсэг” (ma. gu-i čigtengge fuyjingya hergen) үйлджээ.⁵² (10-р зураг)

Аливаа бичгийн журмыг барихгүй аваас ялд унана. Жишээ нь, “Ёслолын явдлын яамны Хичүнгэ баруун этгээд жигүүрт зогсож мөргөх бүр сайд нарын нэр үсгийг хэлж тэр нэрт сайд олныг авч хаанд мөргөмүй хэмээн уншив. Тэр уншихад нэг үг ч эндэхгүй” хэмээсэн буй.⁵³ Энх-Амгалангийн үед Хаан бээр фүши түшмэл Жян Юн Сю-д буулгасан зарлигтаа “Эдүгээ бичгийн ард муу суртлыг халахгүй, бичгийн журмыг үл илэрхийлэх нь цөм сургуулийг захирах олон түшмэд, миний санаанд нийлүүлэн үл чадах тул болой...Харьяат олон фү, жэү,

⁵⁰ Мөн тэнд, X, 5321-5335 дугаар тал, Бүгд хууль 78-79 дүгээр дэвтэрт үзнэ үү.

⁵¹ Гертрауде Ли (Gertraude Roth Li) 2000, 194-р талд үзнэ үү.

⁵² Жиованни Стари (Giovanni Stary) 1980, 17 дугаар талд үзнэ үү.

⁵³ ДБҮД IX, 4073 дугаар талд үзнэ үү.

сянь жич ти дяогийн зэрэг түшмэд, аливаа сургуулийн засагт холбогдсоныг нь, чи магадыг барьж уламжлан зүндү, сюнфүд мэдүүлэн гаргатугай, буруултугай. ... Чи сайхнаар хичээнгүйлэн дага”⁵⁴ хэмээн сургаснаас бичгийн журам, түшмэдийг сайтар сурган томилж байсныг мэдэж болно. Энх-Амгалангийн 29-р он, “Баярын ёсоор айлтгах бяо бичиг, жянь бичигт, үсэг ташаарах тасалдах, жич тэрслэн улирч дүрмээс зөрчиж ирэх болбоос Явдлын яаманд тушааж ял хэлэлцүүлтүгэй. Бяо бичиг, жянь бичгийг хойш буцааж, дүрмийн ёсоор засан бичиж, нөхөн хүргээж иртүгэй” хэмээв. Мөн “Тэнгэрийн тэтгэсний 44-р он зарлигт, хаан хэрвээ тэдний орчуулгад алдаа олдвол арьсыг нь нь хуулдаг гэжээ.”⁵⁵

1.3. Бичгийн эд хэрэглэлээр хүндэтгэх ёс. Манж албан бичигт хятад, солонгос цаас, артай торго бөс, алт мөнгийг өргөнөөр хэрэглэж иржээ. Жишээлбэл, Цэцэн хааны 9-р оны дансанд, 10 сарын 15-нд солонгосын элч сайд Пиүгийн бичгийн хамтаар авчирсан зүйлийн дотор их цаас 40 товхио, бага цаас 100 товхио болон цагаан цаас 200 товхио ирснийг тэмдэглэжээ.⁵⁶ “Таван хэлний толь”-ийн цаасны зүйлд ма. *tuwabungya hoošan*, мо. *тунхгийн цаас*, хя. *bang zhi* 榜紙, ма. *giyančihuyan*, мо. *хээлсэн хя. jian zhi* 箋紙, ма. *sahaliyan nelgiyen hoošan*, мо. *хар алтан цаас*, хя. *diao jin zhi* 烏金紙, ма. *albani lamun hoošan*, мо. *албаны хөх цаас*, хя. *guan qing zhi* 官青紙, ма. *ayalaha iyangya hoošan*, мо. *лавдсан бидэрт цаас*, хя. *la hua zhi* 蠟花紙 гэх мэт 35 төрлийн цаасны нэр бий.⁵⁷

Эдгээрийн дотроос эрх сүрийг илтгэсэн чамин цаасыг хааны албан хэрэгт хэрэглэж хүндэтгэнэ. Жишээ нь, “Монгол бичгийн гэрийн данс”-ны манж баримтаас үзвэл⁵⁸ Энх-Амгалангийн үед хааны зарлигийн утга агуулгатай уялдуулан ямар цаасанд бичихийг тусгайлан тогтоож, ихэвчлэн *лүнжянь* болон *сянжянь* хоёр зүйлийн цааснаа зарлигийг манж, монгол бичгээр хавсран үйлдэж, тус бүрт зарлиг сургах тамга дарах тухай баримт бүрийн төгсгөлд тодорхой өгүүлжээ. Үүнд,

Сянжянь цаасыг ма. “*wangya giyančihuyan hoošan*”, хя. *xiang jian zhi* 香箋紙, мо. “*сайн үнэрт хээлсэн цаас*” хэмээнэ. “*Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг*”-ийн долдугаар дэвтэрт, “*Үнэрт өвсийг хэмхчин дэвтээж тунгаан хийсэн хээлсэн цаас*” гэжээ. Дансанд тохиолдож буйгаар, нэг луу, дөрвөн үүлт сян жянь цаас, дундаа луугүй тойрон луут их сян жянь цаас зэрэг зүйлтэй байв. Үүнд, Далай ламын амгаланг асуух, илгээх, буулгах зарлигийн бичиг, Өөлдийн хаан, Банчэн хутагтад илгээх болон сайныг асуух зарлиг, Орос улсын Цагаан хаанд буулгасан зарлиг зэргийг сян жянь цааснаа бичжээ.

Лүнжянь цаасыг ма. “*tuduringya ginčihuyan hoošan*”, хя. “*long jian zhi* 龍箋紙, мо. “*луут хээлсэн цаас*”. “*Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг*”-ийн долдугаар дэвтэрт “*хээлсэн цаасанд луу лаавдсаныг нь луут хээлсэн цаас хэмээмүй*” гэжээ. Ерийн болон их лүн жянь цаас гэсэн зүйлтэй бололтой. Өөлдийн Далай баатар тайж, Галдан бошогт, Халхын Түшээт хан, Жавзандамба хутагт, Сэцэн хан, Засагт хан, Халхын долоон хошууны

⁵⁴ “*Dayicing gürün-ü Dotuyadu yatun-u Mongyol bičig-ün ger-ün dangsa*”, I боть, 2006, 489 дүгээр талд үзнэ үү. Хойшид “*Монгол бичгийн гэрийн данс*” гэнэ.

⁵⁵ Кроссли, С. Равски (Crossley, S. Rawski) 1993, 73 дугаар тал, 26 дугаар зүүлтэд үзнэ үү.

⁵⁶ ДБҮД IX, 4513-4515 дугаар талд үзнэ үү.

⁵⁷ *Han-i araha sunja hač'in-i hergen qatcibuha manju gisun-i bidhe*, 1957, 804-815 дугаар талд үзнэ үү.

⁵⁸ *Монгол бичгийн гэрийн данс*, I-XI боть, 2006




жонон, ноён, тайж нар, Дива, Ван будда Авид нарын зэрэгт буулгасан зарлигийн бичигт лүн жиянь цаас хэрэглэжээ. Эндээс “буулгах зарлиг” аваас ийм цаас зарна гэж үзэж болохоор аж.

Хуульд үзвээс, “Жич Дээд цол нэмэх, өргөхийн тул Ёслолын явдлын яаманд буулгах Сургах зарлигийн бичиг болбоос, бэх бийрийн сиян жиянь цааснаа хичээнгүйлэн бичиж, Хааны бообай дармуй. Гадаадад бүхий бичиг цэргийн сайд нар, жич монгол ван нар, чоохияний зэрэг олон улсад буулгах Сургах зарлигийн бичиг болбоос бэх бийрээр шар цааснаа бичиж, Хааны бообай дармуй. Мөргөхоор ирсэн түшмэлдэд буулгах Сургах зарлигийн бичиг болбоос цөм шар цааснаа дармаллаж Хааны бообай дармуй.” гэжээ.

Бас, хаанд айлтгах бичгийг (ма. *wesimbure bidhe*) муутуу цаасанд бичихгүй, заавал тайлянь цаасан дээр бичдэг байна.⁵⁹ Албан хэргийг ихэвчлэн цааснаа үйлдэх боловч, Их Монгол, Юань улсын үеийнх шиг онцгойлон алт зэрэг үнэт эдээр үйлдэх нь ч бас байв.

10-р зураг⁶⁰

11-р зураг⁶¹

		
Тэнгэрийн тэтгэсний үеийн “Улирлыг бадруулах бообай	Түгээмэл элбэгтийн 8-р он, Будда Райдэнд илгээсэн зарлиг	Энх-амгалангийн 6-р он, VI Далай ламд илгээсэн зарлиг.

		
Төр гэрэлтийн 21-р он, XI Далай ламд огсон алтан жуух	Найралт товчын 4-р он, Далай ламд тамга, цол, жуух шагнасан зарлиг	Тэнгэрийн тэтгэсний Далай ламд илгээсэн хас жуух

1.3.2. Бичгийн эдийн онгоор хүндэтгэх. Чингийн үед жир албан байгууллага ер хэрэгцээндээ бор шаргал шугамтай цаас хэрэглэдэг бол төр захиргааны дээд байгууллага улаан шугамтай цаас хэрэглэнэ. Дооших албан газрууд улаан шугам хэрэглэх эрхгүй.⁶² Бичгийн шугамын өнгөөс гадна, тамгын дардас улаан байна. Хаан улаан бийрээр цохно. Үүнийг “улаан бийрээр цохсон” (ма. *fulgiyan fi-i pilehe*) гэнэ. “Шунхан бийр” гэсэн нь бий.⁶³ Ийнхүү цохохын өмнө

⁵⁹ М. Баярсайхан 2010, 138 дугаар талд үзнэ үү.

⁶⁰ Стари 1980, 17 дугаар талд үзнэ үү.

⁶¹ *A Collection of Historical Archives of Tibet*, 1990, 63, 38, 74, 41, 72 дугаар талд үзнэ үү.

⁶² Я. Цэвэл, 1959, 17 дугаар тал, Г. Норовсамбуу, 1975, 68-69 дүгээр талд үзнэ үү.

⁶³ Г. Норовсамбуу, 1975, 70 дугаар талд үзнэ үү.

бичгийг хэрхэн бэлтгэх тухай хуульд, “Аливаа олон явдлын яаманд буулгах Дээд зарлигийг бичгийн эрхин сайд нар, Дээр үзүүлэн айлтгасан хойно, улаан бийрийн шар жээгид буулган бичиж, харьяат явдлын яамны тангийн түшмэлийг авчирч тушаамуй.”; “Аливаа дотоод гадаад яамны айлтгасан бичиг, жич олон түшмэдийн зүйлчлэн айлтгасан бичигт манж бичиг бүхий нь болбоос, бичгийн эрхин сайд, бичгийн дэд сайдын хамт бүгд үзэж няочянь⁶⁴ бичиж айлтгаж, Зарлигийг эрмүй. Хэрбээр хятад бичиг, монгол бичиг төдий нь болбоос, жүншү⁶⁵ нарт өгч орчуулмуй. ...Бичгийн дэдэлсэн сайд, тэмдэглэгч түшмэл засаж нийлүүлж, бичгийн эрхин сайд нарт хүргэж няочянь бичиж айлтгаж, Зарлигийг эрмүй” хэмээн заажээ.⁶⁶ Энэхүү өнгөний ялгамжааг чанд мөрдөж байсан нь монголчуудын цээрлэх ёсонд “Захидлыг улаан шар өнгийн бэхээр бичихийг цээрлэнэ. Хаадын зарлигийг шараар, номын тарнийг улаанаар бичдэг тул тийнхүү хориглоно”⁶⁷ хэмээн шингэсэн байдаг.

Эзэн хаан, түүний эх зэрэг эрхэм хүн наснаас нөгчвөл, улсын их бэлэвсрэлийн хугацаанд албан бичигт улаан шугамыг хөх өнгөөр, нийт газар тамгын улаан тосыг мөн хөх болгон солино.⁶⁸ (12-р зураг) “Зарлигаар тогтоосон Дайчин улсын бүгд хууль бичиг”-т өгүүлснээр, “Илэрхийлсэн өвөг, нэвтрүүлсэн хуанди”-ийн биеэс үндэслэсэн уг салааг “угсаа” хэмээмүй. Их авга нар, бага авга нар, ах нар, дүү нараас үндэслэснийг нь “гиоро” хэмээмүй...Гиоро болбоос улаан дансанд оруулмуй. Хэрэв, угсаа, гиорогийн хүн ял олбоос, түүний төрсөн хүүхдийг шар, улаан дансны эцэст оруулмуй” хэмээснээс үзвэл, “угсаат” хүн шар дансанд бүртгэлтэй ажээ. Аливаа хэрэглэх бийр бэх, цаас, айлтгах бичиг агуулах хайрцаг, шунх, шар лав зэрэг зүйлийг Сангийн болон Үйлдэх явдлын яамнаас авах бөгөөд авсан зүйлийг жилийн эцэст тоог гарган бичиж, сонсгон айлтгана. Ийнхүү бийр бэх, өнгө, шугам хүртэл төрийн эрхийг баригч хаан, түүний ураг удамд хүндлэл үзүүлэх нарийн дэгтэй байв.

1.3.3. Тамга тэмдгийн зүйлээр хүндэтгэх ёс.

Тамгын үүтгэл. Улсын эзнээс эхлээд албан байгууллага, хувь хүн хүртэл бичиг хэргээ үнэн мөн, хүчин төгөлдөр болохыг баталгаажуулах тэмдэг үлдээдэг хэрэгслийг тамга гэх ба түүнийг хэлбэр, агуулгын талаас нь авч үздэг тусгай тамга судлал (*сигиллография*) хэмээх ухаан буй болжээ. Тамганд эзний нэр төр, эрх хэмжээ шингэж байдаг учир тамгыг эрхшээсэн хүн түүний эзний хэмжээнд хүрч очно. Чингийн үед амины хэрэгт зүү бэнь бичгийг хэрэглэж, тамга бүхий түшмэл ч тамга дарахгүй байхаар хуульчлан зааж байсан нь тамга төрийн эрдэнэ болохын илрэл билээ.⁶⁹ Тиймээс бид манж албан бичигт хааныг хүндэтгэхийн нэгэн жишээнд тамгын асуудлыг оруулан үзэж байна.

Манжид тамга гэсэн утгатай “*doron*”, “*boobai*” хэмээх хоёр үг бий. “*Boobai*” нь “эрдэнэ” гэсэн утгатай хятадаас ормол үг (хя. *bao bei* 寶貝), “*doron*” нь хуучин манж үг болно. Хаан эзэн, түүнээс дээших эрхэм хүний тамгыг онцлон “*бообай*” хэмээж, бусдыг “*тамга*” (*doron*) гэнэ. Ийнхүү ялгамжаатай нэрлэх болсон нь монголоос үүдсэн гэж болох баримт байна.

⁶⁴ Хя. *piao qian* 票签, ма. *afahari*, мо. *цохдос* гэнэ. Бичгийн агуулгыг товч дурдан цохолт хийхэд бэлтгэж хавчуулах зурвас цаасыг хэлнэ. Пяочяний газрыг ма. *afahari dahabure ba*, хя. *piao chu* 票处 мо. *цохдос дагуулах газар* гэнэ.

⁶⁵ Хя. *zhong shu* 中书, ма. *dorgi bidhesi*, мо. *дотоод бичээч*. Дотоод яамны айлтгах бичгийг орчуулах, бичих түшмэл болно.

⁶⁶ Бүгд хууль, Дотоод яамны II дэвтэрт үзнэ үү.

⁶⁷ Ц. Нацагдорж, *Монголчуудын цээрлэх ёсны хураангуй толь*, 1993, 26 дугаар талд үзнэ үү.

⁶⁸ Я. Цэвэл, 1959, 17 дугаар талд үзнэ үү.

⁶⁹ Бүгд хууль, Ёслолын яамны 67-р дэвтэрт үзнэ үү.

Дээд эрдэмтийн үе хүртэл манжийн хааны тамгыг тогтмол “*aisin doron*” (мо. алтан тамга) гэж байв. Жишээ нь, “ДБҮД”-нд “*Ван фү нэрт хятадад нэг торгон хувцас нэг лангийн зоос өгч, хааны тамга дарсан бичиг бариулжэ жсан сүмингүэньд зарав*”, “*Холтү сэцэнд Зоригт дархан бэйл нэр өгч, Цэргийн түрүү, авын дунд явтугай. Хоногт шүүс идтүгэй. Ховгүүд ач нар үе халан бусдад мал бүү унуулагтун. Шүүс бүү өг. Уг нэрийг эр нэрлэвээс эмээл тохсон морь, эм нэрлэвээс уужсин хувцас автугай хэмээн алтан тамга дарсан бичиг өгч, сийлсэн эмээл тохсон моринд хуяг дуулга ачижэ шагнав*”, Цэцэн хааны 9-р он, цагаан сарын 19-нд Цахараас урваж ирсэн сайдад Цахар хааны хатныг сайнаар авчирсны тул “*ажнай морь шагнажэ, Дурал дархан бэйлийн нэр өгч, алтан тамга дарсан бичиг өгөв*”⁷⁰ зэргээр тэмдэглэжээ. Дашрамд, нэр цол өгч, улаа шүүсээс чөлөөлсөн зарлиг нь алба гувчуур, улаа, шүүсний хэргийг зохицуулдаг Их Монгол улс, Ил хаант улс, Юань улс зэрэг монголын хаадын монгол бичиг, дөрвөлжин бичгээр уламжилсан зарлигийг⁷¹ эрхгүй санагдуулна.

“*Бообай*” гэсэн үг хожим Цахар монголыг дагуулсан тухай үйл явдлын хам сэдэвт сая тохиолдож эхэлнэ. Угтаа Цахарын Сутай тайху, хөвгүүн Хонгор нарын Цэцэн хааны хүн учирваас өг хэмээн илгээсэн Сэцэн хааны 9-р он, 5 сарын дансанд тэмдэглэсэн бичигт “*Маха самади Сэцэн хаан, Түшээт хан, Сэцэн жонон тэргүүлжэ их бага бэйс, усны бз овгийн Жүрчин улсын Сэцэн хаанд бичиг айлтгав. Айлтгасан учир. Хаан хүнд хас их төр, хамаг улсад сонсох сайн нэр алдар дээрийн учирт, аливаагаас, төр шаажныг мандуулах нэрийг эрэлцү. Манай б түмэн монгол улсын эзэн засаж чадсангүй. Тийнхүү боловч бид мөн нэгэн угсаа дагаж хас их төрийг басхүү сахин суужухуй. Энэ их төрийг санаваас харилцан элч тасрахгүй, сайныг асуулцан явсуу. Ийнхүү явбаас бид буянт хүний биеийг олж төрсөн, хүчирхэг хүчит хаан болсон тус тэр болой. Элчийн нэр Гармаа чойтил сэцэн бандид*”⁷² хэмээх бичгээс монголын талаас эртний сурвалжит их төртэйгөө сануулахын зэрэгцээ эв найрамдуугаар элч солилцон, тусын төрөө сахих санаагаа илтгэсэн авч, Мэргэн дайчин, Ёто, Сахалиян, Хоогэ холхиос хичээнгүйлэн сөгдөж, “*Цахар хааны хөвгүүн, эхнэр, улс, хас эрдэнийн тамга*”⁷³ олж авчирмуу. ...*Ёсолж ав*” хэмээн хаанд бичиг хүргүүлэв.

Энэ явдалд дөрөөлөн тамгаар дамжуулж эрх хэмжээгээ баталгаажуулах санаа гарсныг Нарийн бичгийн яамны заланы занги Боочэн сянь айлтгасан бичгээс мэдэж болно. Үүнд, “*Хааны богд эрдэм төрүүлэхэд дуртай, өршөөл засаг нэвтэрч Тэнгэр энэ бообайг өгсөн нь зэрэг зорилт бус болой. Хаан Үйлдэх явдлын яаманд хурдан зарлиг буулгажэ, нэгэн бообай хайрцаг хийлгэ. Хүрч ирэх өдөр олон сайд нарыг авч Цагаан хэрэм гарч угтажэ, өмнөд хаалга лугаа хааны гэрт оруулжэ тэнгэрийн өгсөнд нийлүүл. Бас тамга олсон учрыг бичиг бичижэ, энэ тамга даржэ, жүрчин, хятад, монгол дуусган сонсо. Тэнгэрийн зарлиг шилжсэнийг олонд ухуул*” гэснийг Хаан “*мөн хэмээв*”.

⁷⁰ ДБҮД VI, 2935, IX, 4371, IX, 4085 дугаар талд үзнэ үү.

⁷¹ D. Tumurtogoo, *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script* (XII-XVI centuries), Institute of Linguistics, Academia Sinica, Taipei, Taiwan, 2006; *Монгол дөрвөлжин үсэгийн дурасхалын судалгаа*, Улаанбаатар, 2002, Ё. Жанчив, *Дөрвөлжин бичгийн монгол дурсгал*, Monumenta Mongolica, Tomus III, Centre for Mongol Studies, Улаанбаатар, 2002.

⁷² ДБҮД IX, 4288, 4291 дүгээр талд үзнэ үү.

⁷³ Монголын “хасбуу” тамга хэмээгдсэн энэ тамгыг бүтнээр ма. “*gui boobai doron*” гэнэ. “Хасбуу”-гийн буу нь бообайн “бао” хя. *bao* 寶 бөгөөд хятад хэлний “ао” хос эгшгийг монгол, манж хэлнээ давхар гэдсээр тэмдэглэдэг тул мо. буу, ма. боо болсон. “ДБҮД”-нд хасыг товчлон “эрдэнийн тамга” (ма. *boobai doron*), бүр хураан “эрдэнэ” (ма. *бообай*) гэсэн байдаг.

9 сарын шинийн 6-нд ёс гүйцэтгэн шар ширээ тавьж хүж асаан, шаазан бүрээ, монгол бүрээ лавай билар үлээж, тэнгэрт 3 сөгдөж 9 мөргөн, Хаан шар цацарт суусан хойно тамгыг өгч, хаан тэнгэрт 3 сөгдөж 9 мөргөөд сууринд суусан хойно “Энэ хас эрдэнийн тамга эртний үе үеийн хаадын хэрэглэсэн эрдэнийн тамга” хэмээн хоёр этгээд жигүүрийн олонд уншин ухуулав.⁷⁴ Ийнхүү Цахарын төр Алтан улсын хаанд очжээ.

“Бообай” олж авсан чухал үйл хэргийг бусад улс гүрэнд мэдүүлэн зарлаж эхлэв. Жишээ нь, Солонгосын элч Сэлан-г Хааны Дотоод яаманд авчирч, хас тамгыг үзүүлэхэд, Сэлан “Үнэхээр тэнгэрийн буянд олсон тамга болой” хэмээн гайхан өгүүлжээ.⁷⁵ Мин улсад ч мөн энэ мэдээ хэдийнээ хүрэв. Жишээ нь, Мингийн Гинжү хотын доторх Зүй Ин Сэ нэрт хүн тэргүүлэн илгээсэн бичигт, “...Энэ тамга, тэнгэр газар хувь зохиосноос тэнгэрийн өгсөн нь буюу. Хятад хан хишиггүй тул монголын гарт гээгдэв. 500 жилийн эцэст Цэцэнханд болмуй. Хойно Мила бурхан лугаа уулзсан хойно, сайн хүн гарч чиний алтан биед дотроос тусалмуй. ...Саньси чиньжинь газрын нэгэн гээгэн хүн зүүдэнд чиний алтан биеийг үзвээс уулзсу хэмээв. ...Дай Юань, Дай Мин 500 жил дүүрэхгүй их Алтан хаан хуучин төрийг дахин хөгжүүлмүй хэмээн хэлэлцмүй. 500 жилийн зуурт эрхгүй богд хүн гармуй хэмээх нь манай хааныг болой. Түмэн түмэн он удтугай”⁷⁶ гэжээ. Энэхүү Мингийн дотроос хавсрахаа өгүүлсэн бичигт нийгэм цагийн эргэлтийг тэнгэрийн санаатай холбон, түүнээ зүүдний бэлгээр нотлон өгүүлсэн нь манжийн үзэл суртал, шашин шүтлэгт гайхалтай таарчээ.⁷⁷

Мөн дансанд өгүүлсэнчлэн, Тогоонтөмөр хаан Даймингийн Хун ү хаанд төр автан Дайдугаас буруулан, Ин чан фүд хальсан хойно тамга гээгдсэнийг 200 гаруй жилийн хойно Цагаан хэрмийн гадна нэг монгол малчин ямааныхаа ухсан газраас олж, түүнээс хойш Бошогт ханд байсныг Лигдэн хаан довтлон олж авсан нь түүний Сутай тайху хатанд байсныг Сэцэн хаан авсан хэмээх түүхтэй, “*жи гао сы боо*” гэсэн 4 хятад үсэгтэй, 2 луу ороосон эштэй⁷⁸ энэ хас эрдэнийн тамга бидний мэдэхээр 1246 онд дарсан Гүюг хааны тамга “Мөнх тэнгэрийн хүчинд Их Монгол Улсын Далайн ханы зарлиг, эл булха иргэнд хүрвээс бүширтүгэй, аюутугай” гэсэн бичигтэй, Юань улсын хаадын зарлиг ямагт “Мөнх тэнгэрийн хүчинд” хэмээн эхэлдэг, улсын бичиг нь дөрвөлжин үсэг байсан зэрэг наад захын зүйлийг харгалзвал, Монгол төрийн “хасбуу тамга” мөн эсэх нь эргэлзээтэй, нягтлууштай хэдий ч, хамгийн чухал нь “Монголоос олдсон”-оороо эрхэм үнэ цэнтэй. Манжийн хааны төрөө засахдаа монгол уламжлалыг харгалзаж байсанд үг зарлигтаа Субашидаас эшлэн⁷⁹, доод түшмэд нь эзэлсэн

⁷⁴ ДБҮД, IX, 4435-36 дугаар талд үзнэ үү.

⁷⁵ Мөн тэнд, IX, 4513 дугаар талд үзнэ үү.

⁷⁶ Мөн тэнд, X, 5135-5146 дугаар талд үзнэ үү.

⁷⁷ Сурвалжид зүүдний ёр бэлгийг хий хоосон бус, харин ч ирээдүйн зөн хэмээн тэмдэглэсэн зүйл цөөнгүй. “Монголын нууц товчоон”-ы §63-д гэхэд Дэй сэцэний зүүдийг тэмдэглэсэн байдаг. Ш. Чоймаа, 2006, 28-29 дүгээр талд үзнэ үү. Манж нарын хувьд ДБҮД IX, 4518 дугаар талд хаан хоёр халиу зүүдэлснийг, X, 4880-4881 дүгээр талд нас нөгчсөн Цэцэн чин ван хааны зүүдэнд үхэр нэхэж зүүдлэгдсэнийг бичжээ. Хаан зүүдээ тайлуулж эртний бичиг үзээд чин ван нэхэж өргөхөд үхрээр т.йх ёс байсныг мэдэж гайхан, ёсчлон гүйцэтгээд амарлиулсан гэдэг. Дашрамд, ма. “*bederehe niyalma*” гэсэн үг ерийн бичвэрт шууд утгаараа “эгсэн, буцсан хүн”-ийг заахаас гадна ертөнцийг үзэх үзэл, шүтлэгтэй холбоотойгоор энэ ертөнцөөс буцсан хүнийг хэлдгийг анхаарууштай.

⁷⁸ ДБҮД IX, 4427-28 дугаар талд үзнэ үү.

⁷⁹ “Хаан бичгийг үзээж өгүүлрүүн, ...Субашидын бичигт өгүүлсэн нь, бие бат болбоос дайны хүн ч дагамуй. Бие батгүй болбоос нөхөр хань ч урвамуй хэмээмүй. Жич Күнзийн өгүүлсэн нь, бие бат болбоос хүнд сэжиглүүлэхгүй. Бие сэжиглэвээс хүн итгэхгүй хэмээжээ...Өөрийн амаар нэгэнт гарсан үгийг няцахгүй болбоос аливаа цөм бат хэмээн санах бөлгөө” ДБҮД IX, 4128-4130 талд үзнэ үү.

газрыг захирах Хубилай хааны аргыг зөвлөж байсан⁸⁰ зэрэг олон жишээ татаж болно.

Пердү “Монгол овгуудтай тогтоосон манж нарын харилцаа улсын эхний жилүүдийн хүчирхэгжилд амин чухал байж, ураг төрлийн болон үзэл суртлын ойр байдал тэднийг холбож байв. 1607 онд монголчуудаас “Сүрэ хүндүлэн хан” хэмээх цол авч, “Сүрэ бэйлэ” болсон нь орон нутгийн овгийн удирдагчаас Төв евроазийн хааны түвшинд аваачжээ. Өвөр азийн аль ч хааны хүчийг нэхэмжлэгч өөрийгөө энэ үзэл суртлын уламжлалтай холбодог” хэмээсэнчлэн⁸¹ энэ хас тамгыг олсон нь Монголын чинээнд хүрэх, улмаар Төв азийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх томоохон хүчин зүйл болсон байна. Үүнээс хойш Манжийн хаан “тамга” (ма. *doron*) хэрэглэхээ байж, “эрдэнэ” (ма. *boobai*) хэрэглэх болжээ.

Тамгын төрөл зүйл. Чингийн үед *бообай*⁸² (хас болон алтан), *тамга* (алтан, алт түрхсэн мөнгөн, гуулин), *гуань фан* (мөнгөн, гуулин), *тяо ги* (гуулин) гэсэн 4 үндсэн тамгын зүйлийг хэрэглэж, тамга тэмдэг барих хүний албан тушаалын хэргэм зэрэгт таацуулан хэлбэр дүрс, хэмжээ, орц, үсэг, үсгийн хэвтгэй байхыг нарийн тогтоож байв.⁸³ Цэцэн хааны 10-р онд, Хаан бичгийн 3 яамны нэрийг тогтоож хэргийг хуваахдаа “Улсын судар тэмдэглэх яам”-нд тамганд бичих бичиг⁸⁴-ийг хамааргажээ. Цэцэн хааны үед Хаан зургаан яамны сайдыг авчирч, “... Урьд та нар биеийг зас. Биеийг засаж төв болгоод, дээдийг өгүүл. Биеийг засахгүй, журмыг хичээхгүй бөгөөд өгүүлсэн ч дээд хүн миний үгийг сонсохгүй. Хүн мөн итгэхгүй. Зургаан явдлын яамны эзэн бэйс, өөр өөрийн явдлын яаманд анх ороход сайд нарыг авч, ирж тамгыг хүлээн авч, 3 зэрэг мөргө. Өөр өөрийн яаманд буцсан хойно, явдлын яамны эрхин сайд, дэд сайд журганы түшмэдийг авч... өөр өөрийн явдлын яамны шашныг тархааж тамгыг гаргаж хэрэглэ. Аливаа хэрэг үгэнд өөр өөрийн явдлын яамны тамга зар”⁸⁵ хэмээснээр улсын тамга төрөл зүйлтэй болсныг илтгэнэ.

Бид “хаан” жишээн дээр үзэж буй тул бусдыг үл дурдан өгүүлбэл, “Бүгд хууль”-ийн 2-р дэвтэрт бичсэнээр хааны бообай 29 зүйл, ордны дотор хадгалах бообай 6, Дотоод хүүд хадгалах бообай 23 аж.

Ордны бообай нь:

1. Хааны тэнгэрт барих бообай (*han-i abqa-de jafara boobai*) Даруй үе халан залгах бообай. Тэнгэр газарт ихэд тайх, гийсэн өдөр, ордны дотор бараан цааснаа бичиг

⁸⁰ Мэйрэн занги Жан сүн жинь айлтгасан бичигт, “Нэгэн зүйл. Аливаа хотын дарга захирсан түшмэлийг бүү халагтун. Тэр уг захирсан түшмэлийг басхүү захируулбаас газрын харьяат иргэний сэтгэл хуучин хуулийг халахгүй болмуй. Түүнд манжийн түшмэдийг дарга тавьж тамга барилж, хуучин түшмэлийг хавсарга. Энэ даруй Их Юань улсын Шизу хааны (Хубилай хаан орч.) явуулсан журам...” ДБҮД IX, 4577-4580 дугаар талд үзнэ үү.

⁸¹ Пердү 2005, 122 дугаар талд үзнэ үү.

⁸² Монгол тогтсон орчуулга нь толь бичигт журамласнаар ма. *boobai*, мо. *эрдэнэ*, хя. *bao*寶 болно. *Таван хэлний толь*, 1957, Хааны зарлигийн зүйл, 265-267 дугаар талд үзнэ үү.

⁸³ Жишээ нь, Солонгос улсын ванд хас ишт алтан тамга, *өнцөгт*, 3 ямх 5 пүн, зузаан 1 ямх, *иой фу үсэг бичнэ*, Төрийн жүн ванд ки линь ишт алт түрхсэн мөнгөн тамга, *өнцөгт*, 3 ямх 4 пүн, зузаан 1 ямх, *иой фу үсэгт*, Гадаад улсын ванд тэмээн ишт алт түрхсэн мөнгөн тамга, *өнцөгт*, 3 ямх 5 пүн, зузаан 1 ямх, *гио дией үсэгт*, Гүнд барсын ишт мөнгөн тамга, 3 яндар, *өнцөгт*, 3 ямх 3 пүн, зузаан 9 пүн, *лио е үсэгт*, 6 явдлын яам, 3 хүүгийн хэргийг бүгд шийтгэгч Мүгдэний 5 явдлын яам, Гадаад мужийг засах явдлын яам, Дотоод хэргийг бүгд захирах яаманд шударга ишт мөнгөн тамга, 2 яндар, *өнцөгт*, 3 ямх 2 пүн, зузаан 8 пүн, *гио дией үсэгт* гэх зэргээр заажээ. *Бүгд хууль* 68-р дэвтрээс дэлгэрүүлэн үзнэ үү.

⁸⁴ ДБҮД X, 4686-88 дугаар талд үзнэ үү.

⁸⁵ *Мөн тэнд*, VIII, 3842 дугаар талд үзнэ үү.

- бичиж, Тэнгэрт түлэх бичигт дармуй.
2. Тэнгэрийн зарлигаар хүлээсэн Дайчин улсын бообай (*abqai hesei aliha daičing gurun-i boobai*) Хааны төрийг илэрхийлмүй.
 3. Хааны бообай (*han-i boobai*) Буулгах яо шэ бичигт дармуй.
 4. Тэнгэрийн хөвгүүн бообай (*abqai jui boobai*) Хамаг богдоод тайх бичигт дармуй.
 5. Зарлиг буулгах бообай (*hese wasimbure boobai*) Гаоминд дармуй.
 6. Зарлигаар сургах бообай (*hesei tačibure boobai*) Жуухад дармуй.

Дотоод хүүд хадгалсан бообай,

7. Хааны бообай (*han-i boobai*)
8. Хааны явуулах бообай (*han-i yabubure boobai*) Шагнах, хишиг хүргэх бичигт дармуй.
9. Хааны бат бообай (*han-i aydun boobai*) Цэрэг дайчлах бичигт дармуй.
10. Тэнгэрийн хөвгүүн явуулах бообай (*abqai jui yabubure boobai*) Гадаад улсад өгөх чэ бичигт дармуй.
11. Тэнгэрийн хөвгүүн бат бообай (*abqai jui aydun boobai*) Гадаад улсын цэргийг дайчлах бичигт дармуй.
12. Зарлиг буулгах бообай (*hese wasimbure boobai*)
13. Зарлигаар сургах бообай (*hese tačibure boobai*)
14. Уудам хол хязгааргүй явдлын бообай (*ončo yoro ječen aqı yabun-i boobai*) Түшмэдэд сургах бичигт дармуй.
15. Хааны өмнөд бообай (*han-i jülergi boobai*) Аливаа жагсаал жагсаах бичиг, битүүмжилсэн бичигт дармуй.
16. Хааны ургийг эрхэмлэх бообай (*han-i niyaman-be wesihulere boobai*) Нэхэж дээд цол өргөх бичигт дармуй.
17. Хааны ургийг урагсах бообай (*han-i niyaman-be niyاملara boobai*) Ван нарт өгөх бичигт дармуй.
18. Тэнгэрийг хичээнгүйлэх иргэнийг өршөөх бообай (*abqa-be ginggulere irgen-be yosire boobai*) Нийслэл хотод мөргөхөөр ирсэн түшмэдэд буулгах бичигт дармуй.
19. Ном судар бичгийг тэмдэглэх бообай (*ging suduri bidhe-be temgetulere boobai*) Аливаа ном судар бичигт дармуй.
20. Бичгийг хичээнгүйлэх бообай (*bidhe-be ginggulere boobai*) Вэнь жан⁸⁶ хууль бичигт дармуй.
21. Улаан бичгийн дарсан дөрвөн этгээдэд тэмдэглэх нь (*fulgiyan bidhei gidaha duin dere-de temgetulere*) Хааны хол илгээх бичгийн битүүмжид тэмдэглэн дармуй.
22. Дэлхий дахинаа тойрон байцаах бообай (*abqai fejergi-be šurdeme baičara boobai*) Гарч цагдан явахад аваачмуй.
23. Сургахыг үлээх бообай (*tačibure-be werire boobai*) Улсын хуулийг тархаамуй.
24. Заяасан эрдмийн бообай (*hesebuhe erdemui boobai*) Шударга сайныг хөхүүлэх бичигт дарна.
25. Тэнгэрийг хичээнгүйлэх (*abqa-be ginggulere*) Өвгөдийг дууриах, сайчуудыг амраглах,

⁸⁶ Вэнь жангийн үгс хэмээх нь утга уянгын үгийг хэлнэ. Үүнд ямар үгс орохыг жишээлбэл, Дээрээс “дэлхий дахиныг нэгтгэн засах, эрдэм сургаалыг дэлхий д.хинд тархах” зэргийн вэнь жангийн үгсийг хэдий бичиж илгээвч, тэд үл мэдэхийн тул хасаж, ухахад хялбар болгон засаж айлтга хэмээсэн буй. *Монгол бичгийн гэрлийн данс*, III боть, 557-566 дугаар талд үзнэ үү.

- иргэнийг өршөөх жич засгийн чухал хэргийг туслан бичиж тархаах зэрэг бичигт дармуй.
26. Ялтыг дайлах, иргэнийг амар болгох бообай (*weilengge-be dailara irgen-be elhe obure boobai*) Ялтыг дайлуулах бичигт дармуй.
 27. Түмэн улсыг сурган, төв болгох бообай (*tumen gurun-be tačibume tob obure boobai*) Гадаад улсад илгээх гаоминд дармуй.
 28. Түмэн иргэнийг сурган төв болгох бообай (*tumen irgen-be tačibume tob obure boobai*) Дөрвөн зүгт зарлиг тархаах бичигт дармуй.
 29. Бүгд цэргийг захирах бообай (*uheri čooha-be qadalarā boobai*) Хааны биеэр дайлан явахад хүрээнд хэрэглэх бичигт дармуй.

Хаанаас гадна Тай хуан тайхэу ороосон луун ишт хас бообай, алтан бообай, Хуан тайхэу ороосон луун ишт алтан бообай, Хуанхэу, Хуан гүйфэй, Гүй фэй-д хэмжээ орцоор ялгаатай оцойсон луун ишт алтан бообай, Хошой чин ванд хас ишт алтан бообай хэрэглэнэ.

*Тамга үйлдэх нь “Бүгд хууль”-ийн 68-р дэвтэрт үзвэл, Эзний бообай цутгахыг урьд Шан боо сы яаманд захируулж байснаа хожим Дотоод хэргийг бүгд захирах яаманд тусгайлан тушаажээ. Тамгын манж үсгийг зүүн этгээдэд, хятад үсгийг баруун этгээдэд үйлдэнэ. Тус хуулийн 2-р дэвтэрт бообайн үсэг, бообайн дүрмийг цөм дээр үзүүлэн айлтгасан хойно, Дотоод яамнаас хичээнгүйлэн эрхлэхийг заажээ. Эээр засагчийн 6-р он тогтоосноор, яамны түшмэд Хааны гарч явахад дагаж одвоос, яам бүр ма. “*yaiŋi yabure*” (мо. авч явах) хэмээх 2 үсэгт тусгай тамга цутгуулж хэрэглэдэг байснаа Энх-Амгалангийн 6-р оноос, Хаан гарч явахад, сяний бообай үйлдэж, авч явахад хялбар болгосон байна.*

Хуан тайхэу, Хуанхэугийн алтан бообайд гутгаар зэрэг улбар шар алт, Хуан гүй фэй, гүй фэйгийн алтан бообайд 6 цэн өнгөний алт, Чин вангийн алтан бообайд 5 цэн өнгөний алт хэрэглэнэ зэрэг ялгамжаат орцтой. Тамгыг тогтоосон орц, хэлбэр, хэмжээгээр үйлдэхгүй аваас ял хэлэлцэнэ. Найралт төвийн анхдугаар онд, “*Тамга хэмээх нь элдэв зүйлийн хэргийн тэмдэг. ...Ёслолын явдлын яамнаас хэдэн тамга хургэсэн хойно, хамт Чинь тянь чянь яаманд тушааж, сайн өдөр сонгож цутгаж ог. Хэрбээр, наагуурдаж осолдон хичээнгүйлэхгүй болж, байцаан гаргаваас, Тангийн түшмэдийг хамтатган ялах*” зарлиг буулгаж, түүний дагуу, “*...сайн өдрийг сонгуулж, Ёслолын явдлын яамны сыгийн түшмэдэд тусгайлан тушааж, үзэж үйлдүүлэн эрхгүй нарийн тодорхойгоор сийлүүлэн, үсгийн зурхайг төв сайн болгон үйлдүүлмүй. Цутган үйлдэж барсан хойно, Ёслолын явдлын яамны тан-гийн түшмэд тодорхойлон үзэж, үзэж үйлдсэн түшмэдийн нэрийг дансанд тэмдэглэмүй. Хэрбээр, мөнгөний өнгө хүрэхгүй, гууль сайнгүй болбоос, жич үсгийн зурхай тодорхойгүй, хэргийг осолдон наагуурдваас, үзэж үйлдсэн сыгийн түшмэдийг нэр заан буруулж, харьяат явдлын яаманд тушааж, хүндлэн ял хэлэлцэж бас хувиар нэмж толүүлмүй*” хэмээн тогтжээ.

Жич, жил бүрийн цагаан сард тамга битүүмжилж нэг сар хэрэглэхгүй. Бүгд хуулийн 2-р дэвтэр, Дотоод яамны зүйлд зааснаар, тамга битүүмжлэх өдөр, Хааны бообай угаахдаа урьд өдөр бичгийн эрхин сайд нар айлтгаж, угаах өдөр, дяньжи, бичгийн дэд сайдыг дагалцан, Чянь чин мэнь хаалганд одож, тайган нар гаргасан хойно, арилган угааж, хайрцагт агуулна. Хааны тамга угаахад хэрэглэх юмыг харьяат явдлын яамнаас авч хэрэглэнэ. Тамга битүүмжлэх нээх нь, Эээр засагчийн улиралд тогтоосноор, Явдлын яам зэрэг яамд, жил

бүр тамга битүүмжлэх нээх явдлыг урьдаар Ёслолын явдлын яамнаас Чинь тянь гянь яаманд бичиг явуулж, өдрийг сонгуулж, сонгосон өдөр ёсоор битүүмжилнэ, нээнэ. Тамга битүүмжилсэн хойно эрүү хорыг явуулаггүй, хэрэг шийтгэхгүй. Гагцхүү чухал яаралтай хэргийг шийтгэнэ. Энэ хооронд үйлдсэн бичгийн тамга дарах хэсэгт “*тамга битүүмжлэв*” хэмээн улаан бийрээр бичнэ. (13-р зураг)

Бообай дарах нь “*Бүгд хууль*”-ийн 2-р дэвтэрт заасан хэм хэмжээтэй бөгөөд тэрхүү журмыг өөрчлөн шинэчилсээр байв. Үүнд, хааны аливаа бообайг Эсэр засагчийн анхдугаар онд тогтоосноор Дотоод гурван яамны бичгийн эрхин сайд, бичгийн дэд сайд бүгд үзэж байж дарна. 18-р онд, Дотоод яамнаас урьд өдөр ма. “*sakini*” (мо. *мэдтүгэй*) хэмээх бичиг илгээж, Дотоод тайганы хамт үзэж дарах болов. Энх-Амгалангийн 9-р онд, гаомин жуухын бообайг Дотоод яам, гэрийн сайдын хамт Чянь чин мэнь⁸⁷-д үзэж дарсугай хэмээн айлтгаж явуулав. 12-р он, гаомин, чымин, жуухад дарахдаа айлтгахаа больж, чухал хэрэгт эрж айлтгах болов.

Монгол албан бичгийн уламжлалд ямар тохиолдолд хаа хаа тамга дардаг тухай өмнөх судлаачид бичгийн нүүр, оруулга, нөхвөр, засвар, цаасны залгаа, он сар, мөр тэтгэсэн үг, хуудасны үдээ дээр зэргээр дурдсан байдгийг Чингийн үед мөрдөж байв.⁸⁸ (14-р зураг) Энэ тухайд Чин улс хуульчлан заасан байдгаас “бяо” бичгээр жишээлбэл, “*Бүгд хууль*”-ийн 67-р дэвтэрт бичсэнээр, Найралт төвийн анхдугаар он, бяо бичгийн өмнө дээд нүүрт, тамгын мэт их, нэг шар цаас наалдуулж, цаасны доодод тамга дармуй. Шар цаасанд бяогийн төрлөөс хамааран “*Түмэн насны гийсэн өдөр баярын ёсоор айлтгах бяо бичиг*”, “*Шинийн нэгний баярын ёсоор айлтгах бяо бичиг*”, “*Өвлийн туйлын өдрийн баярын ёсоор айлтгах бяо бичиг*” хэмээн бичиж, эцэст жил, сар, өдрийн бичсэн газарт мөн тамга дарна. Битүүмжид шар цаас наалдуулж, өмнөх ёсоор бичээд, шар цаасны доодод тамга дараад, доор нь *тэр түшмэл, сайд тэр* айлтгах нь, хичээнгүйлэн битүүмжлэв хэмээн бичмүй. “*Айлтгах нь*” (ма. *wesimburengge*), “*хичээнгүйлэн битүүмжлэв*” (ма. *gingguleme fempilehe*) хэмээх үсгийн газарт тамга дарах ажээ. Хаанд баярын ёсоор илэрхийлэн айлтгах бяо бичигт шар цаас наах нь Хаан шар цацарт сууж, шар хувцас өмсөж, шар ширээ тавих, угсааны үрсийг шар дансанд тэмдэглэх зэрэг ерөөс хааны хамаат зүйлд шар өнгийг эрхэмлэдгийн учир гэж үзэж болох юм. Тиймээс, нөгөө талаар бусад иргэн шар торго өмсөх, 5 хумст луу оёхыг хориглон, гагц Хаан өгсөн тохиолдолд сая өмсөх эрхтэй.⁸⁹


Ийнхүү Цахар монголын хасбуу тамгыг эрхшээснээс хойш Алтан улсаас Манж Чин улс болтлоо хааны нэр алдар түгэн, улс улмаар мандан хөгжиж хүндлэл туйлд хүрчээ.

⁸⁷ Бээжин дэх Чингийн хааны ордны хаалганы нэг болох “*Чянь чин мэнь*” хаалгыг монголоор “*Цэлмэг огторгуйн үүд*”, “*Тунгалаг огторгуйн хаалга*” зэргээр нэрлэх ба энд хаан аливаа айлтгалыг сонсож, хэрэг шийддэг байжээ.

⁸⁸ Я. Цэвэл 1959; Я. Цэвэл 1962, 85-107 дугаар тал, Г. Норовсамбуу, 1975, 82-83 дугаар тал, Ц. Шагдарсүрэн, 2001, М. Баярсайхан 2010, 140 дүгээр талд үзнэ үү.


⁸⁹ ДБУД VIII, 3887 дугаар талд үзнэ үү.

12-р зураг




M1: Д1 3313-9

13-р зураг



M1: Д1 4126-3

14-р зураг



M1: Д1 3877-3

2. Дотоод агуулгаар хүндэтгэх ёсны хүрээнд хэл найруулгын хүндэтгэлийг авч үзье. Хааны тухайд ямар үгийг хэрэглэж болох, үл болохыг дүрэмлэн нарийвчилж, үгийн хүнд хөнгөнийг тааруулж эхэлсэн нь Манжийн Чин улс олон улсыг цэргийн хүч, төрийн бодлогоор нэгтгэн засаж эхэлсэн түүхэн үйл явдалтай холбоотой агаад хаанаа тэдгээр үндэстнүүдийн оройн хүчин болгон ухуулахдаа бичигт үгийн хүчийг ашиглах болжээ.

Дээд эрдэмт (1636-1644)-ийн анхдугаар оны 6 сарын шинийн 6-нд буулгасан зарлигт⁹⁰, “Богд хааны зарлиг. Манай улс хууль мэдэхгүй үед, үг зарлиг боловч, бичиг бичивч, дээд доод, эрхэм доордыг ялгахгүй бөлгөө. Эдүгээ эртний хуулийг үзвээс, дээрээс өгүүлэх, доороос явуулахыг цөм өөр өөр ялгажухуй...” хэмээнээс энэ ёс Дээд эрдэмтийн үеэс эхэлснийг тодорхой мэдэж болох юм. Ингээд мөнхүү зарлигт үгийн зохисыг анх үүсгэсэнээр,

“Бичиг заалдах хүн Хаанд болбоос “Богд Хаанд айлтгамуй” (ма. *enduringge han-de wesimbumbi*), Чин ван, жүнь ван, бэйл нарт болбоос “заалдмуй” (ма. *habšambi*), сайд нарт болбоос “хэлмуй” (ма. *alambi*) хэмээмүй.

Хааны үгийг бичигт бичих, зүгээр хэлэлцэх үед ч “Хааны зарлиг” (ма. *han-i hese*) хэмээмүй. Хаан ямарваа үг хэлэхэд “зарлиг буулгав” (ма. *hese wasimbuha*) гэнэ. Доод хүн хаанаас асуух, өчихийн аль алинд “үг айлтгамуй” (ма. *gisun wesimbumbi*) хэмээмүй.

Хаанд үйлчлэх хүмүүсийн нэр ч ялгамжаатай болов. Үүнд, сайд нарыг “хэргэмт” (ма. *hergen*) бус, “түшимэл” (ма. *hafan*) гэнэ. Дотоод, гадаад хошой чин ван, жүн ван, төрийн жүн ван, төрийн бэйл нар харилцан явах элчийг “элч” хэмээмүй. Гадаад дагасан монголын элчийг “элч хэмээхгүй”. Морь, эд хүргэж ирвээс “морь эд хүргээр мөргөж ирсэн” хэмээмүй. Заалдан ирвээс, “үг айлтгаар ирэв” хэмээмүй. Ванд ороогүй их бага бэйл нар, бэйс нарын элч Чин ван, жүн ванд ирвээс элч хэмээхгүй, “хүргээж ирсэн хүн” гэв.

Урьд “улсад ташаарах цалгардах шажин үгүй”, “шажны бичиг барцулав”, “манай түшимэл цэрэгт шажин буулгаж”⁹¹ зэргээр “шажин” хэмээх үгийг хууль, ёс гэсэн утгаар хэрэглэж

⁹⁰ ДБҮД Х, 4877-4879 дүгээр талд үзнэ үү.

⁹¹ Мөн тэнд, IX, 4167, 4434, 4579, дугаар талд үзнэ үү.

байсныг дээрх зарлигаар “...*Шажин хэмээх нь бурханы шажин. Үүнээс хойш “шажин” хэмээн бүү өгүүллэгтүн. Манай улсын үгээр “цааз” (ма. *fafun*) хэмээн өгүүл*” гэв.

Мөн “*доорамби*” хэмээх нь монголын үг.⁹² Үүнээс хойш бичигт бичивч, ерийн үгэнд боловч “*доорамби*” хэмээхийг маш боль. Цөм “*алхудамби*” хэмээ” гэжээ.

Энэ бол улс гүрэн улсын дайтай болж ирэхдээ, хэдий бусдын үлгэрээс сайныг нь ававч, өөрийн юмыг цолгоруулж, тэлсэн хил, арвитсан хөрөнгөдөө дүйлгэн “*эх хэлнийхээ нийгмийн үүргийг дээшлүүлэх*”-эд бодлогоор анхаардгийн нэгэн жишээ ажээ.

Манж нар гадаад улстай харилцахдаа үгийн тунг сүрхий тааруулж байсныг тэдний албан баримт гэрчилнэ. Тодруулбал, Даймин улсын “*Хуандид барив*” (ма. *hūwangdi-de jafaha*) хэмээн эхэлдэг бол Даймин улсын “*сайд нарт илгээв*” (ма. *ambasa-de unggihe*) гэнэ.⁹³ Үүнээс дээд зэрэгтэйд “*барьж*”, түүнээс доодод тодорхойгоор “*илгээнэ*”. Тэгэхээр нэг талаас бүхэл бүтэн улсын байр суурийг хэрхэн тодорхойлж байсныг нь чухам аль үгийг сонгосноор таних боломж гарч ирнэ гэсэн үг. Яг ийм утгын нарийныг харилцах бичигтээ манж нарыг ямагт “*Дээд улс*” (ма. *wesihun gurun*) хэмээн зай авах буюу мөр тэтгэн бичиж ирсэн⁹⁴ Солонгосын ван мэдэрч ухамсарласан баримтыг эшилбэл, “*Солонгос улсын вангийн хариу бичиг. Алтан улсын хаанд барив. ...Илгээв, барив хэмээх нь цөм хөрш улс харилцан хичээнгүйлэн өргөх нь буюу. Урьд хойч бичгийг нээж үзвээс, Дээд улсын зарим нэг бичигт мөн “барив” хэмээх үсэг бичжээ. Доод улсад тэр нэгэн үсгийг хэрхэн хайрлах аж. Эдүгээгийн “илгээв” хэмээх үсгийг би мэдэж бичсэн нь бус. Эдүгээ ирсэн бичгийг үзэж тэсгэлгүй солив*”⁹⁵ гэжээ. Үнэхээр “ДБҮД” дахь Манжийн хааны удаа дараагийн бичгүүдэд Солонгосын ванд “*барив*”, заримдаа “*илгээв*” гэж аль алинаар хаягласан байдаг бөгөөд “*барих*” гэсэн үсгийг хойшид манай улсад яахан “*хайрлах*” (зэргэдийн түвшинд асан бол үүний оронд “*бичих, өгөх*” зэрэг үгийг хэрэглэх байсан биз ээ) гэсэн 2 үгийн тайлбараар Солонгосын тал “*илгээсэн*” бичиг авахад бэлхэнээ дуртгаснаараа тэднийг бүрмөсөн хүлээн зөвшөөрч дагалдсанаа илэрхийлжээ.

Үгийг тааруулан оноох дүрэм журмыг заримдаа албат иргэнээс санал болгож байв. Жишээ нь, Шулуун улааны сумын занги Сюй си чан “...*Нэгэн зүйл. Урьд ханыг нэхээс нэр өгвөөс зохимуй. Эртний ди ван нэхээс нэр өгөх нь өвөг эцгийн төр байгуулсан зузааныг алдаршуулах хөвгүүд ач нар мөрөөсөх сэтгэлийг гүйцэтгэх үнэнхүү их ёс болой. Урьд хан улсыг байгуулж хязгаарыг нээв. Хэргийг бадруулсан нь эртнээс нааш цөөн зэргээс тасарсан гавьяа болой. Хурдан айлдаршуулж хойч үед үлдээвээс зохимуй. Хальж 9 жил болтол нэхээс нэр өгсү хэмээх мэдээг өчүүхэн ч сонссонгүй. Эдүгээгийн сайд, иргэн цөм урьд хан (ма. *nepene han*) хэмээмүй. Энэ нэрийг зуун үед түмэн жилд үлдээвээс зохино уу? Миний мунхгаар санах нь, Ёслолын явдлын яаманд хэлж хурдан зөвлөлдөж нэхэн нэр өгч эрхгүй урьд хааны их гавьяанд нийцүүлэн Хааны элсэг сэтгэлийг явуул. Сайн өдөр сонгон нэр өгч, урьд хааны тэнгэрт бүхүй богд сүнснээ тааруулан хааны ачлалт сэтгэлийг гүйцэтгэ. Нэгэн зүйл. одоо болтол нэгэн их улс тул гагцхүү “*бичгийн гэр*” (ма. *bidhei boo*) хэмээвээс болно уу? Миний мунхгаар санах нь, Зүн шү яам байгуулж, зүн шү тин ван, зүүн баруун этгээд чэнчян цань жсэн сы-гийн зэрэг*

⁹² “*дууриах*” гэсэн монгол үг манж хэлэнд орохдоо хоёрдугаар үеийн хос эгшиг нь богино “*а*” болжээ.

⁹³ ДБҮД VIII, 3865-3871 болон VII, 3180, VIII, 3868 дугаар талд үзнэ үү.

⁹⁴ Мөн тэнд, IX, 4131, 4132, 4458, 4459 дүгээр талд үзнэ үү.

⁹⁵ Мөн тэнд, X, 4613-4614 дүгээр талд үзнэ үү.

сайдьг тавьж зөвлөх туслах болгож улсын аливаа их хэргийг цөм зөвлөж явбаас улсад ташаарах цалгардах шаажин үгүй. Хааны шөнө өдөр зовох нь мөн цөөн болмуи⁹⁶ хэмээжээ. Энд хятад хүн хятад суртал загварыг дурдах нь зүйн хэрэг.

Бидэнд үг бүрийн тухайд дээр өгүүлсэн мэт зарлиг баримт үгүй авч, хуучин ямар үгийг буулгасан зааврын дагуу өөрчлөн мөрдсөнийг “ДБҮД” дахь хуучин бичсэн үгийг алдаа болгон дарж балласан хэсгүүдийг сайтар үзвэл мэдэж болохоор байна. Үүнд,

Хуудасны дугаар	Хуучин үг манжаар	Монголчилбол	Шинэчлэн зассан нь манжаар	Монголчилбол
3241	han-i gisun-i	Хааны үгээр	hesei	зарлигаар
3802	γajime	авчрав	benjime jihe	хүргэж ирэв
3824, 3884, 4017	buhe	өгөв	šangnaha	шагнав
3830	han-de qarulame	хаанд хариулж	wesimbume	айлтгаж
3835	bidhei booi	бичгийн гэрийн	bidhei yamun-i	ямны
3837	han-de tuwabuha bidhei gisun	хаанд үзүүлсэн бичгийн үг	wesimbuhe	айлтгав
3851, 3988	han-de alaha	хаанд хэлэв	wesimbuhe	айлтгав
3852	geren hafasa hendume	олон түшмэд өгүүлрүүн	wesimbuhe	айлтгав
3887, 3989, 4003, 4033, 4043, 4048	wasimbuha bidhei gisun	буулгасан бичгийн үг	han joo bidhe wasimbuha	хаан жуу бичиг буулгав
3989	ama han	эцэг хаан	taizu	Тайзү
3989	aisin gurun	Алтан улс	manju	Манж улс
3989	menggün dejifi waliyafi	мөнгө түлэн гэж	wecēfi	мөнгө түлэн тайж
4003, 4033, 4043, 4047, 4048,	han hendume	хан өгүүлрүүн	han joo bidhe wasimbume hendume	хаан жуу бичиг буулган өгүүлрүүн
4032-33, 43	gisun aqū	үггүй	hese aqū	зарлиггүй
4053	aisin gurun-i cečen han hendume	Айсин гүрний Цэцэн хан өгүүлрүүн	manju gurun-i cečen han-i hese	Манж улсын цэцэн ханы зарлиг

Эдгээр үгсийг нэг хэсэг баллан засаад, хойших зүйлд шууд зохистой үгийг хэрэглэх болсон нь сүүлийн дэвтрийг бичиж дуусахаас өмнө зарлиг гарч мөрдсөнийг гэрчилнэ. Жишээ татахад, урьд хааны гэрийг тогтмол ма. “*boo*” гэж байснаа ма. *genggiyen elhe boo* (мо. *гэгээн амгалан гэр*), ма. *genggiyen elhe boode wesike* (мо. *гэгээн амгалан гэртээ дэвиш*) гэжээ.⁹⁷

Бас хаанд айлтгасан бичгүүдээс тогтсон хэллэгийг түүвэрлэж болно. Хааны ач буян их, түүнд нэгэн сэтгэлээр зүтгэхээ олонхын илэрхийлснээс жишээлбэл, “*Зоригт би иударгаар хянан хүч өгсүү, дайн цэрэгт болбоос захиран цаазлан явсугай, гацаанд аж төрөөс худал хулгайгүй иударга аж төрмүү. Хаан өршөөн тэжээхэд Чаргай би үүнээс өмнөш хулгай худал зусар зальхайгүй, хааны тушаасан эсурмыг иударга сэтгэл барьж зөрчихгүй хичээн,*

⁹⁶ Мөн тэнд, IX, 4166-4167 дугаар талд үзнэ үү.

⁹⁷ ДБҮД X, 4799, 4877 дугаар талд үзнэ үү.

аж төрсүү. Хааны сургасан шударга цаазыг зөрчихгүй аж төрвөөс миний хөвгүүд ач нар үе халан хаанд өршөөгдөн эрхэм аж төртүгэй. ”⁹⁸ г.м.

Хүндэтгэл илэрхийлэх оор нэгэн арга нь “Цэргийн явдлын яамны Ёдо бэйл Хаанд айлтгасан бичгийн үг, Миний мунхаар санах нь...”, “Дүсэ чинь жинь хэмээхийн мунхаг санааг сонсгомуй”, “Бао чэн сяний болгоомжлон айлтгах нь”⁹⁹ гэх мэтээр өөрийн биеийг хол доошлуулсан үгээр хааны биеийг өргөх явдал байна.

Ийнхүү Манж Чин улсын анхны хаан бага улсын бага ёсыг их улсын их ёс болгосныг “Тайзүн гэгээн шүхуанди их туйлыг анх байгуулж, дүрмийг тогтоов, гавьяаг илэрхийлүүлэв” хэмээн үнэлж түүхэнд үлдээжээ.¹⁰⁰

Үүнээс хойш утга аялгууны зохисыг үзэн, үгийг улам бүр тааруулах болсон байна. Тухайлбал, маш тайван тувшин болж, ихэмсэглэн тогтоосон тул гавьяа шалгарах, тор бадрав¹⁰¹ хэмээсэн Энх-амгалангийн 30-р оноос, аливаа баярын ёсоор айлтгах бяо бичгийн дотор¹⁰² ма. *alimbaharaqū* (мо. тэсгэлгүй) хэмээх үсгийг хойд талд бичүүлэв.¹⁰³ Мөн энэ үед, Далай лам амрыг эрсэн (ма. *elhe-be baiha*) бичгийн хариуд хаан “Чиний амрыг асуун айлтгасан бичиг, барьсан бэлгийг үзэв. (*elhe-be fonjime wesimbuhe bidhe, jafaha beleg-be tuwaha*) Би тэнгэрийн хишигт амар сайн. ...туслан (ма. *ᠰohome*)¹⁰⁴ засгийн Омбо гэлэн, Ачит гэлэн нарыг зарж, сайныг асуух ёсоор (ма. *sain-be fonjire doroi*) бүслүүрт алтадсан жаран лангийн мөнгөн домбо 1...илгээв”¹⁰⁵ гэсэнээс үзвэл, хааны амрыг эрж айлтган бэлэг барьдаг байхад, хаан сайны асууж бэлэг илгээдэг байна.

Дээд эрдэмтийн анхдугаар оноос үүсгэсэн багшийг эрхэмлэн тайхыг хойчийн хаад ёсчлон дагаж ирсэн бөгөөд Найралт төвийн 2-р он, “залрах” (ма. *enggelere*)-ыг “сургуульд одмуй” (ма. *genembi*) хэмээн халах зарлиг буулгав. Шалтгааныг Хаан “Би үзвээс, судар бичигт басхүү сургууль яаманд “залрахаар одов” (ма. *enggelenehe*) хэмээн бичсэн нь ихэд. ...Энэ нь доод сайд нарын эзнийг эрхэмлэх үг. Миний санаанд маш амаргүй. Эдүгээ тайх өдөр ойр болов. Миний бие одож ёсолсуу хэмээмүй. Үүнээс хойш айлтгах бэний ижүүд “энгэлэмби” хэмээвээс нийцэхгүй. Сургуульд одмуй хэмээн халбаас зохимуй хэмээв.¹⁰⁶ Мөн оноос ти бэньд “мэдтүгэй хэмээн айлтгав” (ма. *sakini seme wesimbuhe*) хэмээх үсгийг бас халж, “сонсгон айлтгав” (ма. *donjibume wesimbuhe*) хэмээв.¹⁰⁷ Үүнээс, доод хүний хүндлэх үг, хаан өөрийнхөө тухайд хэрэглэх үг найруулгыг гярхай анзаарсан хэлний мэдрэмжийг харж болно.

⁹⁸ ДБҮД V, 2339, 2340, 2344, 2348, 2462 дугаар талд үзнэ үү.

⁹⁹ Мөн тэнд, VIII, 3659, IX, 4126-28, 4128 дугаар талд үзнэ үү.

¹⁰⁰ Бүгд хууль, 3-р талд үзнэ үү.

¹⁰¹ Мөн тэнд.

¹⁰² Түмэн насны гийсэн өдөр, шинийн нэгэн, өвлийн туйлын өдөр баярын ёсоор хаан, тай хуан тайху, хуан тайхууд айлтгахад “бяо” бичиг, хуанхууд “жянь” бичиг барина.

¹⁰³ Бүгд хууль, 67, 78 дугаар дэвтэрт үзнэ үү.

¹⁰⁴ “Энэ, уг, уул” гэсэн утгатай “тус” (мб. *tus*) язгуураас бүтсэн “тусла/х” (мб. *tusla/qu*, ма. *ᠰohome*) хэмээх үйл үг нь “тухайлан” гэсэн санааг илэрхийлдэг албан бичгийн тогтсон үг юм. Ач буяны “тус” (мо. *tusa*)-аас бүтсэн “нэмэр болж, дэмжш тэтгэх” утгатай “тусла/х” (мб. *tusala/qu*)-аас ялгаатай.

¹⁰⁵ Монгол бичгийн гэрийн данс, II боть, 2005, 300-302 дугаар талд үзнэ үү.

¹⁰⁶ Бүгд хууль, Сургуулийг үзээр одсон ёс, 61-р дэвтэрт үзнэ үү.

¹⁰⁷ Бүгд хууль, 67-р дэвтэрт үзнэ үү.

Сүүлийн үед судалгааны эргэлтэд орж буй шинэ сэргэг баримтын¹⁰⁸ үндсэн дээр манж-монгол албан бичгийн орчуулгын уламжлалыг харьцуулан судлах таатай боломж гарч байна. Эдгээрээс хааны тухайд зарим нэгэн жишээ татвал,

- Манж баримтад: “*abqai hesei forgon-be aliha quwangdi-i hesē*” хэмээснийг үгчлэн орчуулбал “тэнгэрийн зарлигаар улирлыг эрхэлсэн хуандийн зарлиг” нь монголоор “тэнгэрийн бошгоор цагийг эзэлсэн хуандийн зарлиг” болно.
- ма. “*jalafun abqai hesei hūsun-i hurduṅ-be tooselara abqa na-i erhetu manjusiri dergi han-i genggiyen-de*” хэмээхийг үгчилбэл “өлзий тэнгэрийн зарлигийн хүчээр хүрдийг эргүүлэгч тэнгэр газрын эрхт Манзушири дээд хааны гэгээнээ”, мо. “Мөнх тэнгэрийн ивээлээр хүчний хүрд орчуулагч, тэнгэр газрын эрхт Манзушири дээд хааны гэгээнээ”. Дашрамд, Манжийн хааныг “Манзушири” хэмээн өргөмжлөх болсон нь 1652 онд Эээр засагч, V Далай ламыг Бээжинд залж золгох үеэр Далай ламаас Манжийн хаанд “Огторгуйн тэнгэр Манзушири дээд их эзэн” алдар өргөснөөс үүджээ.

Энэ мэтээр харьцуулан үзэхэд хэл, түүх, сэтгэлгээний талаас олон сонирхолтой баримт гарч болох бөгөөд хожим тухайлан авч үзнэ.

Росс, Шиньжи болон түүний эхийн нэрийг дурдаад, эдгээр чимэг үгс хоёр дахин нэмэгдсэн бөгөөд урт нь хүндэтгэлийн зэргийг харуулна гэжээ.¹⁰⁹ Үнэхээр монголчуудаас олгосон “Цэцэн хүндлэн хаан” нэр цол цагийн аясаар үгийн охь шимийг хураасаар ма. “Тэнгэрийн бошгоор цагийг эзэлсэн хуанди”, мо. “Аль дөрвөн тив мэт таван өнгө улсыг эзэлснээ, уулсын хаан сүмбэр уул мэт богдын алтан биед алимад сайн үйлсийн үрс илэрхий өндөр болгогчдоо ариун хоёр ёсны наран саран мэт орчуулагч эзэн богд” болтолоо нэмэгдэж, “хаан ухаж мэд” (ма. *han seuleme sa*) хэмээсэн бичиг “зарлигийн ёсоор тольдоно уу, тольдоно уу” (ма. *hesei songqoi bulekušereu, bulekušereu*¹¹⁰) хэмээн эрж, “зуун нас олон аж төртүгэй” гэх ерөөл “түмэн насны гийсэн өдрийн бяо бичиг” болон хүндэл туйлд хүрчээ.

3. Орчин нөхцөлөөр хүндэтгэх ёсонд хааны албан бичигт холбогдох ёслолын зүйлийг авч үзье. Хааны зарлиг бичгийг ерийн харилцаа шиг гараас гарт дамжуулчихдаггүй, хаанаас өөрцгүй ёс төртэй ханддаг байжээ. Энэ талаар Дээд эрдэмтийн үеэс эхлэн бичсэн буй. Хуучин насны ахмадыг бодож асан манж нар зэргийг урьтах болсон төрийн ёсны дагуу хааны зарлигийн бичиг ирэх аваас ван тэргүүлэн бүгд мориноосоо буун, баруун этгээдэд жагсан зогсоно. Зарлигийн бичиг өнгөрсөн хойно, араас нь мордож, зарлиг гэрт хүрэхэд, ширээнд хүж асааж, бичиг авчирсан сайд, бичгийг ширээнээ тавиад, зүүн жигүүрт баруунш хандан зогсмуй. Ван нэгэн зэрэг сөгдөж гурван зэрэг мөргөөд, сөгдсөөр ахуйд бичиг аваачсан сайд бичгийг ширээнээс авч, унших хүнд өгөхөд унших хүн зогсоогоор уншиж дуусаад ванд хүлээлгэн өгөхөд ван хоёр гараар хүлээн аваад, өөрийн хүнд өгч нэг зэрэг сөгдөж гурван зэрэг мөргөөд, зарлигийн бичгийг урьд хадгалуулж, ван, сайд харилцан нэгэн зэрэг сөгдөж, нэгэн зэрэг мөргөн ёсолсон хойно сая зарсан сайд зүүн этгээдэд, ван баруун этгээдэд эсрэгцэн суух аж.

¹⁰⁸ “Монгол бичгийн гэрийн данс”, I-XXII, 2006, “Дайчин гүрний эхэн үеийн Гадаад монголын төрийг засах явдлын яамны манж, монгол айлтгалын дэвтрүүд”, I-XXIII, 2010.

¹⁰⁹ Росс 1973, 530 дугаар талд үзнэ үү.

¹¹⁰ ма. “*bulekušereu, bulekušereu*” хэмээхийг үгчлэн орчуулбал, “тольдоно уу, тольдоно уу” болох ба монгол баримтад харин “айлд, айлд” гэсэн байдаг.

Хааны зарлигийн бичгийг хэлэхэд ван сөгдөж сонсоно.¹¹¹

Зарим бичгийг хүссэн нь айлтгаж үл болно. Жишээлбэл, бяо бичгийн ёсыг Энх-Амгалангийн 55-р онд хуульд оруулсан тул 56 оны Түмэн насны гийсэн өдрөөс эхлэн бичгийн түшмэл болбоос ань ча ши-гээс дээш, цэргийн түшмэл болбоос фүжянгаас дээших тушаалтан айлтгах эрхтэй болов. Газар газраас ирсэн олон бяо бичгийг Дотоод жагсаалыг захирах яамны сяо юй нар тинсэ-д өргөж, сяо фан нар хөгжим үүсгэж, Өмнөд дундадын хаалганы өмнө хүрээд хоёр хажууд жагсан тавьж, Хуанди, дянъд дэвшсэн хойно, нийслэл хотын ван нарын айлтгах бяо бичгийг уншина. Дууссан хойно, өргөн барьж, дотоод яаманд хүргэнэ.¹¹²

Хаанд олон яамнаас нэг бол нүүр уулзаж эсвээс Дотоод яамнаас уламжлан айлтгана. Хаан тусгай хэрэг сонсох өдөр (ма. *dasan-i baita-be donjire inenggi*), шийтгэх өдөр (ма. *baita içihiyara inenggi*)-тэй. Засгийн хэрэг айлтгах ёсонд үзвэл,¹¹³

Энх-Амгалангийн 10-р оноос төрийн хувцас фүз¹¹⁴ хүрэм өмсөх өдөр, айлтгах түшмэд цөм төрийн хувцас, фүз хүрэм өмсөх болов. 14-р оноос, сар бүр яамлах өдөр *Хаан дянъд дэвшвээс* олон ван түшмэл төрийн хувцас өмсөж ёслоод, дотор орж айлтгахдаа гагцхүү фүз хүрэм өмсөнө, *хаан дянъд дэвшихгүй аваас* сайд нар төрийн хувцас өмсөнө.

21-р оноос, хэрэг айлтгахад зовж зүдэхийг харгалзан хаалганд дэвших цагийг сунгаж хавар зун луу цагийн эхний мөч¹¹⁵, намар өвөл луу цагийн төв тэргүүн мөчөөр¹¹⁶ хугацав.

25-р оноос засгийн хэрэг сонсох өдөр олон яам айлтгахдаа манж, хятад хэлэлцэх түшмэл нэжгээд, манж, хятад байцаан үзэх түшмэл нэжгээд гаргаж жагсаалд зогсоох болов.

Найралт төвийн 2-р оноос, хэрэг айлтгахгүй түшмэдийг дэмий оруулахгүй болгов.

Хэрэг шийтгэх өдөр Чянь чин мэнь хаалганаа засгийн хэргийг сонсоход хааны суух исрийг хаалганы төв дунд тавина. Айлтгах бичиг тавих ширээг өмнө нь тавина. Явдлын яамны их бага түшмэд Өмнөд дундадын хаалганы гадна хурж, хавар зун болбоос туулай цагийн төв эхний мөч, намар өвөл болбоос луу цагийн тэргүүн нэг мөчид Дундадын зүүн этгээд хаалганд орж хүлээнэ. Хавар зун болбоос луу цагийн эхний тэргүүн мөч, намар өвөл болбоос луу цагийн төв тэргүүн мөчид Хойд зүүн этгээд хаалганд орно. Хуанди хаалганаа дэвшиж суусан хойно явдлын яамны түшмэд дэс дараалан зүүн этгээд яндарт дэвшиж, тангийн түшмэд айлтгах бичгийг өргөн барьж ширээний өмнө шадардаж сөгдөж тавиад, буцаж зүүн зүгт одож, баруун этгээд хандан сөгдөж айлтгана. Хэрбээр ногоон тэргүүт айлтгах хэрэг байваас, мөн тангийн түшмэд өргөн барьж, хааны суусан исрийн өмнө баруун зүг хандан сөгдөж айлтгана. Олон түшмэд цөм зэргийг үзэн тангийн түшмэдийн хойно сөгдөнө. Нэг яам хэрэг айлтгаж барваас олон түшмэд мөн зүүн этгээд яндраас зэргийг бодон залган буцна. Залган нэг яам шадардаж айлтгахад өмнө ёсоор. Айлтгах дэс нь Түшмэлийн, Сангийн, Ёслолын, Цэргийн, Үйлдэх энэ 5 явдлын яам, Гадаад мужийг засах явдлын яам, Бүгдийг байцаах яам,

¹¹¹ ДБҮД Х, 5157-5160 дугаар талд үзнэ үү.

¹¹² Бүгд хууль, Ёслолын явдлын яамны 67 дугаар дэвтэрт үзнэ үү.

¹¹³ Бүгд хууль, Засгийн хэргийг сонсох ёс, 58 дугаар дэвтэрт үзнэ үү.

¹¹⁴ Хэргэм зэрэгтний хүрмийн ар өвөр болон хоёр мөрөн дээрх ямбаны тэмдгийг фүз гэнэ.

¹¹⁵ Манж нар цагийг эхний, төв, адаг гэсэн үндсэн гурван хэсэгт хувааж, төвийг дотор нь эхэн, адгаар 2 хуваадаг бололтой. Эндэх “эхний тэргүүн мөч” (цји цји ке) нь цагийн эхний 15 минут болно.

¹¹⁶ “Төв тэргүүн мөч” (тов цји ке) нь цагийн 15-30 минутын хоорондох хугацааг хэлнэ.

Түн жэн сы яам, Дай лии сы яам урд хойно жасаалан айлтгана. Хэрэв Зүн жинь фү яам хэрэг айлтгаваас олон яамны өмнө айлтгана. Шүүх явдлын яам хэрэг айлтгаваас өдөр бүр гутгаар жасаанд айлтгана. Олон яам айлтгаж дуусаад өөр өөрийн зэргийг үзэн дараа дараагаар хиадыг даган хойд зүүн этгээд хаалгаар гарна. Дотоод яамны бичгийн дэд сайд өдөр бүр айлтгасан бичгийг хураана. Хэрэв нугалсан хэрэг байваас бичгийн эрхин сайд бичгийн дэд сайд нүүр уулзаж Зарлигийг эрнэ. Босох суухыг тэмдэглэх түшмэд саравчны доороос хааны суусан исрийн өмнө шадардаж хичээнгүйлэн сонсон тэмдэглэмүй. Бичгийн эрхин сайд нар буцсан хойно Хуанди ордонд дэвшмүй.

Дээр эшилснээс, бичиг айлтгахдаа тогтоосон хувцасыг өмссөн олон яамны сайд түшмэд хамаарах тушаалтныг дагуулан товлосон цагт зохих хаалганд очиж, хаан заларсан хойно дотогш орж, оноосон газарт зогсоод, тухайн өдөр айлтгах яамд хуваарилсан дэсээр шадардан сөгдөж айлтгах зуур тусгай түшмэл тэмдэглэн авна. Бүх айлтгал дууссан хойно зэрэг дэсээрээ тогтсон гарах хаалгаар, бичгийн дэд сайд бичгийг хураан авч, дуусан хойно хаан ордондоо заларна гэсэн дүр зургийг цаг, зүг номоор нь харж болно. Сөгдөх босох, дэвших буцахаас эхлэн аливаа ёс алдсаныг нэр заан буруулан айлтгаж ялыг хэлэлцэнэ. Энэ зэргээр жуух, гаомин, чимин, бяо, жянь тэргүүт аливаа бичиг, тэдгээрийг айлтгах ба хүлээн авах ёс, тайх бичигт хэрэглэх юм¹¹⁷ бичгийн дүрэм, түүнд холбоотой ёсыг хуульчилжээ.

“Бүгд хууль”-д хаан сууринд суусан ёсны тэмдэглэл Тайзү дээд хуандийнх 1 нүүр, Тайзүн гэгээн шү хуандийнх 2, Шизү гэрэлт хуандийнх 4, Шэнзү өршөөлт хуандийнх 8 нүүр эзэлж буй.¹¹⁸ Энэ бол гүйлгээд үзмэгц мэдэгдэх баримжаа юм. Дээд эрдэмтийн үед Хаан, Алтан улсын Сизүн хааны бичгийг манжчилсныг уншаад, “*Би энэ бичгийг унхисанаас нааш морь гөрөөсийг үзвээс довтолсуу хэмээн чих сортосхийх мэт миний чих нүд тодорхой гэгээн болжухуй. ...Сизүн Үлү хаанд хүрсэн хойно, угтаа болгоомжлон эртнээс хөвгүүд ач нарыг хятад ёсонд орохгүй хэмээн дахин дахинаар өвгөдийн хуучин ёсыг бүү март. Нюй жи хувцас өмс. Нюй жи хэл сур. Харвах намнахыг боловсруул хэмээн чухам өгүүлжсүхуй. ...Урьд Дахай багш, Хурчан багш манай манжийн хувцас малгайг гээж хятадын хувцас малгайг өмссүү, хятадын ёсыг дагасуу хэмээн намайг дурдах бөлгөө. Би цааргалж болсонгүй. Намайг үг авахгүй хэмээх бөлгөө. ...Хойч үеийн хөвгүүд ач нар хуучин ёсыг гээж харвах намнахыг мартаж хятадын ёсонд орохгүй хэмээн болгоомжлох нь болой*”¹¹⁹ хэмээн өгүүлж байсан хэдий ч уугал нүүдлийн соёлт манж нар хүчирхэгжих шат бүртээ суурин соёлд ойртсоор Бээжинд нийслэллэн идээшиж, дөрвөн богд харилцан залгалдаж, Шэнзү өршөөлт хуандийн үед ихэмсэглэн тогтож,¹²⁰ утга уянга саруул гэрэлтэх тутам ёслол хүндлэл хүндэрсээр байв.

Тус өгүүлэлд, “*хаан*”-д хүндэтгэл илэрхийлэх жишээн дээр манж бичгийн соёлын хөгжлийг улсын мандал бадралын үйл явцтай уялдуулан авч үзлээ. Эхэн үедээ монгол, манж бичгээр

¹¹⁷ Бүгд хууль, 66, 67, 118, 238-р дэвтэрт үзнэ үү.

¹¹⁸ Бүгд хууль, 57-р дэвтэр

¹¹⁹ ДБҮД Х, 5293-5296 дугаар талд үзнэ үү.

¹²⁰ Дөрвөн богд нь Тайзү дээд хуанди (оны цол нь Тэнгэрийн сүлдэт), Тайзүн гэгээн шү хуанди (Цэцэн хаан, Дээд эрдэмт), Шизү гэрэлт хуанди (Эээр засагч), Шэнзү өршөөлт хуанди (Энх-Амгалан) болно. Шэнзү өршөөлт хуанди хар багаасаа ухаалаг сэцний дээр ялангуяа Күнзийн суртал шингээсэн, хятад соёлыг таашаадаг байсныг Тайзүн хуандийн шадар жанжин Хуай вангийн хүү бөгөөд хаан ширээнд суусныхаа дараа үүнийгээ мэдэж, эцгийнхээ хөнөөлгөсний өсөөр хааны охин буюу эгчтэйгээ суусан, манж хүн биш хэмээх хачирхалтай домгийн зүйл байдаг. Росс 1973, 530-548 дугаар талд үзнэ үү.

хавсран үйлддэг албан бичиг "...Дай Ляо, Алтан, Сүн, Дай Юань энэ дөрвөн улсын төрийг хичээн засаж улсыг мандуулсан"¹²¹ шигээ монгол уламжлалд тулж өндийжээ. Тухайн цагт чухамдаа монгол соёл шиг нийцтэй чансаатай үлгэр жишээг өөр хэнээс авах сан билээ. Ид үедээ манж, монгол, хятад гурван хэлээр үйлдэж олон соёлыг шингээн боловсров. Энх-Амгалан, Найралт төв, Тэнгэрийн тэтгэсний үед улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын оргилд хүрсэн үе хийгээд түүнээс хойш манж, хятад хэл түрэн зонхилж, манж бичгийн соёл нь Жяньжоугаас эхлэн улмаар Манжуур, Хятад, Монгол, Төвдийг бүхлээр бүрэн эрхшээсэн ноёрхлоо дагалдан улам бүр боловсрон төгөлдөржжээ. Эцэст нь, манж хууль зарлигийн бичиг, сурвалж, данс хараа, архивын баримтад тулгуурлах нь гагц манж төдийгүй монгол албан бичгийн уламжлалыг судлахад үнэ цэнтэй болохыг онцлон дурдъя.

Ном зүй

- Монгол хэлээр**
 Баярсайхан М. Монгол, манж албан бичгийн харьцаа, Acta Mongolica Tom 7 (291), МУИС, Монгол судлалын төв, Улаанбаатар, 2007, 155-170-р тал.
 Баярсайхан М. Монгол албан бичгийн уламжлал дахь хүндэтгэл илэрхийлэх ёсон, Оюуны хэлхээ, ЭШБ, Боть I (06), Fasc. 13, Антоон Мостаерт төв, Улаанбаатар, 2010, 133-151.
 Дагула Манж хэлэн дэх монгол зээлээ үгсийг ижил гаралтай үгсээс ялгах арга зарчим", Монголын судлалын бүтээлийн чуулган 1, ӨМАХХ, 2006, 160-170
 Добу, *Uiŋurjin Mongyol üsüg-ün durasqaltu bičig-üd, Ündüsüten-ü keblel-ün qorigy-a*, 1983.
 Мижиддорж Го. Манж-монгол хэлний ижил язгуурт үгсийн толь, Хэл зохиол 2, ШУАХ, 1964, 127-186,
 Нацагдорж Ц. Монголчуудын цээрлэх ёсны хураангуй толь, Улаанбаатар, 1993.
 Норовсамбуу Г. Монголын архив-албан хэрэг, түүний бичгийн хэв, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1975.
 Цэвэл Я. Монгол албан бичгийн уламжлал, Studia Mongolica, Tom. I, Fasc. 22, Улаанбаатар, 1959.
 Цэвэл Я. Монгол албан бичгийн уламжлал, - Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал, IV боть, Улаанбаатар, 1962, 85-107-р тал.
 Чоймаа Ш. Монголын нууц товчоон, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, Улаанбаатар, 2006.
 Шагдарсүрэн Ц. Монголчуудын үсэг бичгийн товчоон, Улаанбаатар, 2001.
 Шагдарсүрэн Ц. Монголчуудын утга соёлын товчоон, Улаанбаатар, 2003.

Манж сурвалж

愛新 觉罗, 乌拉春, 滿族古神話, manju aiman julgei enduri juben, 內蒙古人民出版社, 1987, 舊滿洲檔 (*Chiu Man-chou tang*) photoreprint, Taipei, Palace Museum, 1969.

A Collection of Historical Archives of Tibet, Compiled by The Archives of the Tibet Autonomous

¹²¹ ДБУД IX, 4270-4271 дүгээр талд үзнэ үү.

Region, Cultural Relics Publishing House, 1990.

Dayičing gürün-ü Dotuyadu yamun-u Mongyol bičig-ün ger-ün dangsa, I-XXII, 2006

Dayičing gürün-ü ekin üy-e-yin yadayadu mongyol-un törü-yi jasaqu yabudal-un yamun-u manju mongyol ayiladqal-un debter-üd. Töb aziy-a-yin kele teüke sudulul-un material-un čubural, Dumdadu ulus-un Teüke-yin nigedüger arhib, Arad-un yeke suryayuli-yin ulus-un Töb aziy-a-yin kele teüke sudulqu küriyeleng, I-XIII debter, ÖMAKQ, 2010.

Han-i araha manju gisun-i buleku bidhe

Han-i araha sunja hačin-i hergen qamcibuha manju gisun-i bidhe, Ündüsüten-ü keblel-ün qoriy-a, 1957

Я. Шаарийбуу, *Manju suduri bidhe-i deji*, Манжийн утга зохиолын дээж, УБ, 1990.

Англи хэлээр

Franz Michael *The Origin of Manchu Rule in China*, Frontier and Bureaucracy as Interacting Forces in the Chinese Empire. Octagon books.INC., New York, 1965.

Gertraude Roth Li *Manchu: A Textbook for Reading Documents*, University of Hawai'i Press, 2000.

Giovanni Stary *Die chinesischen und mandschurischen Zierschriften*, Helmut Buske Verlag, Hamburg, 1980.

Henry Serruys *Sino-Jürčed Relations During the Yung-Lo Period, (1403-1424)*, Göttinger Asiatische Forschungen, Band 4, Otto Harrasowitz, Wiesbaden, 1955.

Hummel Arthur . W. *Eminent Chinese of the Ch'ing Period, (1644-1912)*, Originally printed by US Government Printing Office, Washington, 1943-44, Reprinted by Literature House, LTD. 143 Chungking South Road, Section I, Taipei, Taiwan, Republic of China, 1964.

Kotwicz Władysław *Les éléments mongols dans le mandchou*, Rocznik Orientalistyczny 14 (1938), pp. 91-102,

Ligeti Louis *Les anciens éléments mongols dans le mandchou*, AOH 10 (1960), pp. 231-248,

Owen Lattimore *Inner Asian Frontiers of China*, American Geographical Society, Research series No. 21, New York, 1940, second edition 1951.

Pamela Crossley *A Profile of The Manchu Language in Ching History*, Harvard Journal of Asiatic Studies, Vol. 53, No.1 (Jun, 1993), pp. 63-102.

Evelyn S. Rawski *New Light on the Origins of The Manchus*, Harvard Journal of Asiatic Studies, Vol. 50, No.1 (Jun., 1990), pp. 239-282.

Pei Huang *China Marches West*. The Qing conquest of Central Eurasia. The Belknap Press of Harvard University Press, Cambridge, Massachusetts London, England, 2005. ISBN 0-674-01684-X

Peter C. Perdue *Ruling from Horseback*, Manchu Politics in the Oboi Regency, 1661-1669, The University of Chicago Press, 1975.

Robert B. Oxnam *The Manchus*, The Reigning Dynasty of China: Their rise and progress, London 1891, First AMS edition, New York, 1973.

Rev. John Ross *Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XII-XVI centuries)*, Institute of Linguistics, Academia Sinica, Taipei, Taiwan, 2006.

Tumurtoogoo D. *Monggol Elements in Manchu*, Indiana University, Bloomington, Indiana, 1994

William Rozycki

ABSTRACT

This paper is related to the writing culture of the Manchu's. There are lots of work done on the history, language and culture of the Manchu's from various angles and perspectives; however, these works are lacking studies on document formatting culture. Under document processing one can observe essential characteristics of writing culture: addressing, content, formulation ...etc. Moreover, it's available to follow utensils that are used in writing like paper quality, brush, ink, color and many other qualities. In addition to this, the receiver of document can judge what level of respect is shown to him. All above mentioned qualities can appear only if this culture of document processing is highly developed. Within the frame of this paper, a standard of writings in different respect forms represented in Manchu archival documents is discussed, taking the example of Manchu Emperor, who was a supreme person of the state.

The main focus is based on three points: forms of writings, content of documents and rituals applied to these documents. Within the scope of writing forms the followings are studied: word positioning, assiduous applications for writings and used stationaries (paper, color, seal and etc). The content considers respect forms in language style. The rituals are related to a particular ceremony of Manchu imperial documents. Once Taizong has said that the Manchu state has been developed according to the tradition of the four states: Dai Liao, Jin, Sung and Dai Yuan. Similarly, the Manchu document processing which was written in both Manchu and Mongolian languages are blossomed on the basis of the Mongolian writing tradition exercised for longer period of the history.

During the historical development, the Manchu state has been originated from just a small guardian unit called Jianzhou which gradually extended to the territory that covered Manjuur, China Proper, Mongolia and Tibet. This powerful political rise directly influenced to the writing culture, particularly in the respect form of document addressed to the King. In the pick of the development of this tradition observed multi-cultural influences and therefore, it used three official languages: Manchu, Mongolian and Chinese.

In the reign of Kangxi, Yongzheng and Qianlong, the Manchus reached to their political, economical, social and cultural zeniths along with the perfection of Manchu written culture which is preserved officially only on Manchu and Chinese. The above mentioned studies are relied mostly on the sources and archival law materials of Manchus which is in my opinion will contributed to the study of the Manchu and Mongolian document processing tradition.